

АГУУЛГА

хуудас

1	Хамрах хүрээ	3
2	Норматив эшлэл	3
3	Нэр томъёо	4
4	Шалгалт явуулах аргачлал	4
4.1	Авто угсрааны амны хөндийн өргөнийг шалгах № 821 р-1 загвар	5
4.2	Цоож өргөгчийг шалгах № 847 р загвар	7
4.3	Бага шүдний урт ба амны цохилтын хананаас том шүдний татах гадаргуу хүртэлх зай шалгах № 892 р; 893 р; 894 р загварууд	11
4.4	Авто угсрааны холболтын хүрээг шалгах № 827 р загвар	15
4.5	Бага шүдний ба амны хөндийн цохилтын гадаргууг шалгах 914/24-1 загварын гадаргуу	17
4.6	Ордоггүй шуп № 914/21 а	21
4.7	Авто угсрааны амны хөндий ба бага шүдний мөлүүгийн өнцөг шалгах № 822 р загвар	22
4.8	Авто угсрааны толгойн халаасны өргөн шалгах № 845 р загвар	24
4.9	Авто угсрааны толгойн халаасны өргөн шалгах № 848 р загвар	26
4.10	Өргөгчийн голын нүхний тэнхлэгийн давхцал ба диаметруудийг шалгах № 797 р загвар	28
4.11	Авто угсрааны холболтын хүрээг өргөгчийн голын нүхний байрлалтай харьцуулан давхцалыг шалгах № 937 р загвар	31
4.12	Цоож баригчийн өлгүүрийн өндөр шалгах № 849 р загвар	34
4.13	Цоож баригчийн өлгүүр хурууны диаметр шалгах № 806 р загвар	36
4.14	Цоож баригчийн өлгүүр хурууны байрлалыг холболтын хүрээтэй харьцуулж шалгах № 816 р загвар	38
4.15	Цоож баригчийн өлгүүр хурууны байрлалыг өргөгчийн голын нүхтэй харьцуулж шалгах № 938 р загвар.	42
4.16	Урьдчилан хамгаалагчийн дээд мөрний тавиурын байрлалыг шалгах № 834 р загвар	44
4.17	Авто угсрааны сүүл хэсгийн шаантаг нүхний зузаан шалгах № 897 р-1; 898 р-1; 900 р-1 загварууд	49
4.18	Авто угсрааны сүүл хэсгийн шаантаг шалгах № 46 Г загвар	52
4.19	Авто угсрааны цоожны зузаан шалгах № 852 р загвар.	54
4.20	Авто угсрааны цоожны зузаан шалгах № 899 р загвар.	57
4.21	Авто угсрааны цоожны өргүүрийн байрлал ба диаметрийг шалгах № 833 р загвар	59
4.22	Зүүван нүхний арын ирмэгийг шалгах № 839 р загвар	63
4.23	Цоожны тулгуурын чиглүүлэгч шүд шалгах № 943 загвар	67
4.24	Цоож баригчийн зузаан ба саварын өргөн шалгах № 841 р загвар	68
4.25	Авто угсрааны цоож баригчийн зууван нүх ба салгах өнцгийн эсрэг жин шалгах № 826 р загвар.	71
4.26	826 р загварыг шалгах № 824 р загвар.	76
4.27	826 р загварын сухарийн ордоггүй хэсгийн байрлалыг шалгах № 830 р тохируулгын загвар	80
4.28	826 р загварын сухарийн ордог хэсгийн байрлалыг шалгах № 825 р тохируулгын загвар	81
4.29	Цоож баригчийн гадаад нүхийг шалгах № 916 р загвар	83
4.30	Авто угсрааны урьдчилан хамгаалагчийг шалгах № 800 р загвар	89

4.31	Өргөгчийн голонцор шалгах № 919 загвар	90
4.32	Авто угсрааны залгалтын хүрээ шалгах № 828 р загвар	94
4.33	Авто угсрааны салгах механизм ба цоожны урьдчилан хамгаалагчийн ажиллагааг шалгах № 820 р загвар	96
4.34	Бага шүдний ирмэгээс цоожны холдох хэмжээ шалгах №787 р загвар.	99
4.35	Шингээх аппаратны дарагч конусыг шалгах № 611 загвар	101
4.36	611 загварыг шалгах 611 к загвар	103
4.37	Угсрагдсан Ш-1-Т; Ш-1-ТМ шингээх аппаратны оврын хэмжээг шалгах № 83 р ба 83 р/1 загварууд	105
4.38	Татах хомын урт ба толгойн хэсгийн тавиурын өндрийг шалгах № 920 р-1 загвар	106
4.39	Шаантаг суух нүх ба хомын толгойн хэсэг дэх нүхний өндрийг шалгах № 861 р-М загвар	108
4.40	Ачааны болон зорчигчийн вагоны розетканы дүүжин зүүлтний толгой суух суурийн гадаргууг шалгах № 776 р; 779 р загварууд	111
4.41	Ачааны вагоны тэнцүүлэгч хавтанг шалгах № 777 р-м загвар	113
4.42	Зорчигчийн вагоны тэнцүүлэгч хавтан шалгах № 780 р-М загвар	116
4.43	Ачааны вагоны дүүжин зүүлт шалгах № 778 р загвар	119
4.44	Зорчигчийн вагоны дүүжин зүүлт шалгах № 781 р загвар	121
4.45	Авто угсрааны байдал ба түүний механизмүүдийн үйлчлэлийг шалгах № 940 р хосолсон загвар	123
4.46	Авто угсрааны байдал, түүний механизмүүдийн үйлчлэлийг шалгах № 873 загвар	127
4.47	847 р загварын хяналтын № 901 р загвар	131
4.48	Авто угсрааны том шүдний татах гадаргууг шалгах № 914 р/25 загвар	132
4.49	Авто угсрааны жижиг шүдний татах гадаргууг шалгах № 914 р/22-М загвар	135
4.50	№ 827 р загвар шалгах № 889 шалгалтын загвар	137
4.51	№ 828 р загвар шалгах № 896 шалгалтын загвар	138
5	Шалгалтын үр дүн	140
6	Хавсралт	141

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 17.040.30

Хөдлөх бүрэлдэхүүний авто угсрааны үзүүлэлтүүдийг шалгах хяналтын болон ажлын загварууд. Баталгаажуулалтын арга хэрэгсэл	MNS..... :2022
Control and working models of rolling stock auto assembly devices. Method of verification	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2022 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2022 оны оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн хүчинтэй.

1. Хамрах хүрээ

Энэ стандарт нь өргөн царигийн төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний авто угсрааны үзүүлэлтийг шалгах хяналтын болон ажлын загваруудад хамаарч, тэдгээрийн анхдагч болон ээлжит баталгаажуулалтын арга хэрэгслийг тогтооно.

Энэ стандартад ажлын болон хяналтын загварын техникийн зургийг ашиглалт ба засварын дараахь шалгалтын үед тодорхойлох хяналтын хэмжээсийн хамт оруулсан. Эдгээр техникийн зураг нь тухайн загварыг үйлдвэрлэх техникийн баримт бичиг болохгүй.

Хөдлөх бүрэлдэхүүний авто угсрааны үзүүлэлтүүдийг шалгах загварууд нь анхдагч болон ээлжит баталгаажуулалтанд хамрагдана. Ашиглалтын болон засварын дараа, мөн удаан хадгалалтын дараа (1 жилээс илүү) ажлын болон хяналтын загварууд нь энэхүү арга хэрэгслийн дагуу ээлжит бус баталгаажуулалтанд хамрагдана.

Хяналтын болон ажлын загваруудын ээлжит болон ээлжит бус баталгаажуулалт хоорондын хугацааг байгууллагын удирдлага тухайн загварын ашиглалтын нөхцөл, хэрэглээнээс хамааран тогтоож болно.

2. Норматив эшлэл

Энэ стандартад дараах эш татсан баримт бичгийг хэрэглэнэ. Хугацаа заасан эшлэлийн хувьд иш татсан хэвлэл, хугацаа заагаагүй эшлэлийн хувьд хамгийн сүүлийн хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

- MNS ISO/IEC Guide 99:2011, Хэмжил зүйн олон улсын тайлбар толь. Үндсэн ба ерөнхий асуудлууд, холбогдох нэр томьёо

- MNS 6387-3 : 2013, Төмөр зам. Хөдлөх бүрэлдэхүүний нэр томьёо, тодорхойлолт
- MNS ISO 3650:2005, Бүтээгдэхүүний геометр тодорхойлолт (БГТ) Уртын эталон-төгсгөлт уртын хэмжүүр
- MNS ISO 13385-1:2015, Бүтээгдэхүүний геометр тодорхойлолт (БГТ). Уртын хэмжлийн багаж хэрэгсэл. 1-р хэсэг: Штанген багаж, загвар, хийц ба хэмжил зүйн үзүүлэлт
- MNS ISO 3611: 2016, Гадаад хэмжлийн микрометр, загвар хийц ба хэмжил зүйн үзүүлэлтүүд
- MNS ISO 14253-1:2017, Бүтээгдэхүүний геометр тодорхойлолт. Эд анги, хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгад нийцсэн байдлыг батлах дүрмүүд

3. Нэр томьёо

- 3.1. **“хөдлөх бүрэлдэхүүн”** - зүтгүүр, вагон, мотовоз зэрэг төмөр замаар явдаг техник
- 3.2. **“авто угсраа”**- хөдлөх бүрэлдэхүүнүүдийг хооронд нь автоматаар холбох, тодорхой зайд барих, найдвартай цоожлогдох, их бие ба түгжих механизмууд болох цоож, цоож баригч, урьдчилан хамгаалагч, цоож өргөгч, өргөгчийн гол, голын боолт зэргээс бүрдсэн, ашиглагдах байдлаараа хатуу ба хатуу биш ангилагдах, дагуу тэнхлэгт нэг шулуун дээр байрлах, дэс дараалалтайгаар угсрагдах галт тэрэгний бүрэлдэхүүний бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах үндсэн эд анги
- 3.3. **“хяналтын загвар”**- ажлын загварыг шалгах зориулалттай хэмжил зүйн тогтоосон үзүүлэлт бүхий техник хэрэгсэл
- 3.4. **“ажлын загвар”**- бүтээгдэхүүний геометр хэмжээсийг шалгах зориулалт бүхий техник хэрэгсэл

4. ШАЛГАЛТ ЯВУУЛАХ АРГАЧЛАЛ

Шалгалтын орчин, түүнд бэлтгэх

- Шалгалтын үеийн орчны температур $(20 \pm 5) ^\circ\text{C}$,
- Агаарын харьцангуй чийглэг $(35 \pm 10) \%$
- Шалгалтын орчны гэрэлтүүлэг энгийн – 150 лк, өдрийн – 300 лк-ээс багагүй байна.
- Баталгаажуулалтын өмнө загварыг шалгалт гүйцэтгэх орчинд 2 цагаас доошгүй хугацаагаар байлгана.

- Баталгаажуулалтанд ашиглах хэмжих хэрэгслүүд, хяналтын загварууд нь зохих стандартын шаардлага хангасан, нэгж дамжуулалтыг бүрэн хангасан шалгалт тохируулгын гэрчилгээтэй байна.
- Ажлын болон хяналтын загварын гадаргуугийн барзгарыг эталон загвартай харьцуулан харж тодорхойлох ба зөвшөөрөгдөх хэмжээг ажлын гадаргуу тус бүрд заасан болно.

4.1. Авто угсрааны амны хөндийн өргөнийг шалгах № 821 p-1 загвар

4.1.1. № 821 p-1 загварын (зураг-1) шалгалтыг 1-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.



Шалгалтын үйл ажиллагаа	Зүйлийн дугаар	1-р хүснэгт Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.1.3	тийм	тийм
Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.1.4	тийм	үгүй
Хяналтын хэмжээг шалгах	4.1.5	тийм	тийм

4.1.2. Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслийг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-73;
- төгсгөлт уртын багц хэмжүүр MNS ISO 3650:2005;
- төгсгөлт уртын багц хэмжүүрийн дагалдах хэрэгслүүд ГОСТ 4119-76.

4.1.3. Гадна үзлэгийн явцад загварын гадна байдал нь Т 416.01.000 СБ ПКБ ЦВ зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно. Загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн болон гадаад үзэмжид нөлөөлөх бусад сэв согоггүй байна.

4.1.4. Загварын ажлын гадаргуугийн барзгар 12,5 мкм-ээс ихгүй байна.



Зураг 1. Авто угсрааны амны хөндийн суналтыг шалгах

4.1.5. Хяналтын ($152 \pm 0,1$) мм хэмжээг төгсгөлт уртын хэмжүүр, түүний дагалдах хэрэгслүүдийн тусламжтай шалгах ба зөвшөөрөгдөх алдааны хязгаарт байна.

4.2. Цоож өргөгчийг шалгах № 847 р загвар

4.2.1. Загварын (зураг - 2) шалгалтыг 2-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.

2 – р хүснэгт

Шалгалтын үйл ажиллагаа	зүйлийн дугаар	Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.2.3	тийм	тийм
Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.2.4	тийм	үгүй
Хяналтын хэмжээг шалгах	4.2.5	тийм	тийм

4.2.2. Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслийг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-93;
- төгсгөлт уртын багц хэмжүүр MNS ISO 3650:2005;
- микрометр MNS ISO 3611:2015;
- № 901 р хяналтын загвар (зураг Т 416.24.000 СБ);
- шупны цуглуулга № 4 ТУ 2-034-225-87;
- төгсгөлт уртын багц хэмжүүрийн дагалдах хэрэгслүүд ГОСТ 4119-76;
- микрометрэн нутромер МН-175 ГОСТ 10-88.

4.2.3. Гадна үзлэгийн явцад загварын гадна байдал нь Т 416.23.000 СБ ПКБ ЦВ зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно. Загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн болон гадаад үзэмжийг муутгасан бусад сэв согоггүй байна.

4.2.4. Загварын ажлын гадаргуугийн барзгар 12,5 мкм-ээс ихгүй байна.

4.2.5. Шалгалтын үед загварын хяналтын хэмжээ 3-р хүснэгтэд заасны дагуу байна.

4.2.5.1. Ордоггүй нүхний 34,1 мм ба 39 мм хэмжээг микрометрээр тодорхойлно.


4.2.5.2. Ордог нүхний 31 мм ба 39 мм хэмжээг

а) засвар эсвэл үйлдвэрээс гарсан үед микрометрээр тодорхойлно.

Хазайлт нь (-0,1 мм) –ээс ихгүй бол зөвшөөрнө.

б) ашиглалт ба хадгалалтын үед штангенциркулээр тодорхойлно.

Хазайлт нь (-0,5 мм)-ээс ихгүй бол зөвшөөрнө.



Зураг 2. Цоож өргөгчийг шалгах № 847 р шаблон

3-р хүснэгт

Хяналтын хэмжээний нэр	Зүйлийн дугаар	Хяналтын хэмжээний утга, мм	Ашиглалтын элэгдлийн хүлцэл, мм	Загварын хяналтын хязгаарын хэмжээ, мм	
				Үйлдвэр болон засвараас гарсан үед	Ашиглалт болон хадгалалтын үед
1	2	3	4	5	6
Ордоггүй нүхний хэмжээ	4.2.5.1	34,1-0,1 39-0,1	-- --	34,0-34,1 38,9-39,0	34,0-34,1 38,9-39,0
Ордог нүхний хэмжээ	4.2.5.2	31-0,1 39-0,1	-0,5 -0,5	30,9-31,0 38,9-39,0	30,5-31,0 38,5-39,0
Ухлаадасны дотоод хяналтын зураас (эд анги.5)	4.2.5.3	зургийн дагуу	--	зургийн дагуу	зургийн дагуу
Хөдлөх нүхний хэмжээ	4.2.5.4	30,9-0,1	-0,5	30,8-30,9	30,4-30,9

		38-0,1	-0,5	37,9-38,0	37,5-38,0
Суурийн оролтын ухлаадасны урт	4.2.5.5	158+1	+0,5	158,0-159,0	158,0-159,0
Өргөгчийн нарийн хуруу шалгах хэсэг дэхь суурийн орох ухлаадасны урт	4.2.5.6	21+0,3	0,5	21,0-21,3	21,0-21,5
Суурийн оролтын ухаадасны өргөн	4.2.5.7	51,5+0,2	+0,5	51,5-51,7	51,5-52,0
Өргөгчийн нарийн хуруу шалгах хэсгийн суурийн орох ухлаадасны өргөн		17+0,2	+0,5	17,0-17,2	17,0-17,5
Ордоггүй тулгуурын өндөр	4.2.5.8	48,5-0,2	--	48,3-48,5	48,3-48,5
Өргөгчийн приливийг хянах орох ухлаадасны өргөн	4.2.5.9	10±0,1	+0,5	9,9-10,1	9,9-10,5
Тэнхлэгийн төвөөс сухарийн оролт хүртэлх зай	4.2.5.10	127-0,2	+0,5	126,8-127,0	126,8-127,5
Тэнхлэгийн төвөөс сухарийн ордоггүй хүртэлх зай	4.2.5.11	123-0,2	--	122,8-123,0	122,8-123,0

4.2.5.3. Ухлаадасны дотоод хяналтын зураасыг 901 р маягийн шалгалтын загвараар шалгана. Шалгалтын загварыг хөдлөгч нүхэнд, үлдсэн хэсэг нь ухлаадаст орж байхаар өмсүүлж шалгана. Загварын ухлаадас ба шалгалтын загвар хоорондын дурын цэгийн завсар зайг шупаар тодорхойлно.

Завсар зайны зөвшөөрөгдөх хэмжээ нь засвар болон үйлдвэрээс гарсан үед 0,3 мм-ээс ихгүй, ашиглалтын үед 0,5 мм-ээс ихгүй байна.

№ 901 р хяналтын загвар нь ажлын загварын хяналтын зурааст орохгүй байвал зөвшөөрөхгүй.

4.2.5.4. Хөдлөх нүхний 30,9 мм, 38 мм хэмжээг

а) засвар болон үйлдвэрээс гарах үед микрометрээр тодорхойлох ба хазайлт нь (- 0,1 мм)-ээс ихгүй байхыг зөвшөөрнө.

б) ашиглалт эсвэл хадгалалтын үед штангенциркулээр тодорхойлох ба хазайлт нь (- 0,5) мм-ээс ихгүй байхыг зөвшөөрнө.

4.2.5.5. Суурийн оролтын ухлаадасны урт 158 мм-ийг штангенциркулээр тодорхойлно. Хазайлт нь (+1,0) мм-ээс ихгүй байхыг зөвшөөрнө.

4.2.5.6. Өргөгчийн нарийн хуруу шалгах хэсгийн суурийн орох ухаадасны 21 мм уртыг бодит утга 158 мм-ээс (4.2.5.5 дагуу хэмжсэн) **X** хэмжээг хассан ялгавраар тодорхойлно. **X** хэмжээг штангенциркулээр тодорхойлно.

Хяналтын хэмжээний хазайлт нь дараахь хэмжээнд байна. үүнд:

а) үйлдвэрээс гарсан үед (+0,3) мм-ээс ихгүй.

б) ашиглалтын үед (+0,5) мм-ээс ихгүй.

4.2.5.7. 51,5 мм ба 17 мм хэмжээг төгсгөлт уртын хэмжүүр, тэдгээрийн дагалдах хэрэгслийн тусламжтайгаар тодорхойлно. Хэвийн утгаас хазайх хазайлт дараахь хэмжээнд байна. Үүнд:

а) үйлдвэрээс гарсан үед (+0,2) мм-ээс ихгүй;

б) ашиглалтын үед (+0,5) мм-ээс ихгүй.

4.2.5.8. Ордоггүй тулгуурын 48,5 мм өндрийг төгсгөлт уртын хэмжүүр, тэдгээрийн дагалдах хэрэгслийн тусламжтай тодорхойлно. Төгсгөлт уртын хэмжүүрийн багцыг бэхлэхдээ захын нэг хэмжүүрийг нь бага зэрэг дээшлүүлнэ. Хэмжилт хийхдээ төгсгөлт уртын хэмжүүрийн багцын дээшлүүлсэн төгсгөлт уртын хэмжүүр нь тулгуурын толгой доогуур орж байхаар байрлуулна. Хэвийн хэмжээний хазайлт (-0,2) мм байхыг зөвшөөрнө.

4.2.5.9. 10 мм хэмжээг тодорхойлохдоо:

а) засвараас болон үйлдвэрээс гарсан үед төгсгөлт уртын хэмжүүр, шуп ашиглана.

Зөвшөөрөгдөх хазайлт ($\pm 0,1$ мм)-ээс ихгүй байна.

б) ашиглалтын болон хадгалалтын үед штангенциркуль ашиглана.

Зөвшөөрөгдөх хазайлт (+ 0,5 мм), (- 0,1 мм)–ээс ихгүй байна.

4.2.5.10. 127 мм хэмжээг эргэдэг нүхнээс сухарийн ордог хэсэг хүртэлх зай ба эсрэг ирмэгүүдийн хоорондох хөдлөх нүхний хэмжээний хагас хэмжээний нийлбэрээр тодорхойлно.

Энэ тохиолдолд хөдлөх нүхний ирмэгийн хагасыг дайруулан, мөн шүргэх хавтгай, сухарийн хэмжлийн гадаргуу зэрэгт перпиндикуляр байхаар хэмжлийг гүйцэтгэнэ. Эргэдэг нүхнээс сухарийн ордог хэсэг хүртэлх бодит хэмжээг гурван хэмжилтийн арифметик дундажаар тооцно.

а) үйлдвэрээс болон засвараас гарсан үед хазайлт (-0,2 мм)-ээс ихгүй байх ба микрометрэн нутромер ашиглан хэмжинэ.

б) ашиглалтын болон хадгалалтын үед хазайлт (+ 0,5 мм), (- 0,2 мм)-ээс ихгүй байх ба штангенциркуль ашиглан хэмжинэ.

Тэнхлэгийн төвөөс сухарийн ордоггүй хэсэг хүртэлх зайг 4.2.5.10-д заасны адил тодорхойлно.

Хазайлт (- 0,2 мм)-ээс ихгүй байх ба нутрометрэн микрометр ашиглан хэмжинэ.

4.3 Бага шүдний урт ба амны цохилтын хананаас том шүдний татах гадаргуу хүртэлх зай шалгах № 892 р; 893 р; 894 р загварууд

4.3.1 Загваруудын (зураг – 3,4) шалгалтыг 4-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.

Шалгалтын үйл ажиллагаа	зүйлийн дугаар	4-р хүснэгт Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.3.3	тийм	тийм
Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.3.4	тийм	үгүй
Хяналтын хэмжээг шалгах	4.3.5	тийм	тийм

4.3.2 Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслийг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-93;
- төгсгөлт уртын багц хэмжүүр MNS ISO 3650:2005;
- төгсгөлт уртын багц хэмжүүрийн дагалдах хэрэгслүүд ГОСТ 4119-76;
- багц шуп №4 ТУ 2-034-225-87.

4.3.3 Гадна үзлэгийн явцад загвар бүрийн гадна байдал нь дараахь зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно. Үүнд:

892 р загвар – зураг Т 416.00.001;

893 р загвар – зураг Т 416.00.002;

894 р загвар – зураг Т 416.00.003 ПКБ ЦВ.

Загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн болон гадаад үзэмжийг муутгасан бусад сэв согоггүй байна.

Загвар нь мурийж тахийсан байж болохгүй.

4.3.4 Загварын ажлын гадаргуугийн барзгар 12,5 мкм-ээс ихгүй байна.

4.3.5 Шалгалтын үед загварын хяналтын хэмжээ 5-р хүснэгтэнд заасны дагуу байна.

Хяналтын хэмжээний нэр	Зүйлийн дугаар	Хяналтын хэмжээний утга, мм	Ашиглалтын элэгдлийн хүлцэл, мм	5-р хүснэгт Загварын хяналтын хязгаарын хэмжээ, мм	
				Үйлдвэр болон засвараас гарсан үед	Ашиглалт болон хадгалалтын үед

<u>892 р загвар</u> Загварын дотор ирмэгүүдийн хоорондын зай	4.3.5.1	103-0,2	-	102,8-103,0	102,8-103,0
		120,2+0,1		120,2-120,3	120,2-120,3
<u>893 р загвар</u> Дотор ирмэгүүдийн хоорондын зай	4.3.5.1	101-0,2	-	100,8-101,0	100,8-101,0
		122,2-0,1		122,2-122,3	122,2-122,3
<u>894 р загвар</u> Дотор ирмэгүүдийн хоорондын зай	4.3.5.1	104,4±0,2	-	104,2-104,6	104,2-104,6
		104,4±0,2		104,6-105,0	104,6-105,0
		118,4±0,2		118,2-118,6	118,2-118,6
		118,8±0,2		118,6-119,0	118,6-119,0
Гадна ирмэгүүдийн хоорондын зай					

4.3.5.1 Хяналтын:

№ 892 р загварын – 103 ба 120,2 мм;

№ 893 р загварын – 101 ба 122,2 мм;

№ 894 р загварын – 104,4; 104,8; 118,4; 118,6 мм хэмжээг дагалдах хэрэгслийн тусламжтай бэхэлсэн төгсгөлт уртын багц хэмжүүрээр тодорхойлно. Хэмжилтийг Т 416.00.001; Т 416.00.002; Т 416.00.003 зурагт заасан хэмжээний шугамын ирмэг хүртэл гүйцэтгэнэ.

Хэмжээний утгууд нь дараахь зөвшөөрөгдөх хязгаарт байна.

Загвар 892 р

102,8 – 103,0 мм

120,2 – 120,3 мм

Загвар 893 р

100,8 – 101,0 мм

122,2 – 122,3 мм

Загвар 984 р


104,2 – 104,6 мм

104,6 – 105,0 мм



118,2 – 118,6 мм

118,6 – 119,0 мм

ТАЙЛБАР: Тухайн байгууллагад хэмжлийн микроскоп ашигладаг бол түүнийг ашиглан шалгалтыг гүйцэтгэхийг зөвлөж байна.



Зураг 3. Бага шүдний урт ба амны цохилтын хананаас том шүдний татах гадаргуу хүртэлх зай шалгах № 893 р загвар



Зураг 4. Бага шүдний урт ба амны цохилтын хананаас том шүдний татах гадаргуу хүртэлх зай шалгах № 892 р; 894 р загварууд

4.4 Авто угсрааны холболтын хүрээг шалгах № 827 р загвар

4.4.1 Загварын (зураг - 5) шалгалтыг 6-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.

Шалгалтын үйл ажиллагаа	зүйлийн дугаар	Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.4.3	тийм	тийм
Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.4.4	тийм	үгүй
Хяналтын хэмжээг шалгах	4.4.5	тийм	тийм

4.4.2 Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслийг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-93;
- хяналтын загвар 889 р (зураг Т 416.00.004);
- шупны цуглуулга № 4 ТУ 2-034-225-87;
- төгсгөлт уртын хэмжүүрийн завсар зайн загвар, хавтгай шилэн ялтас ПИ 60 мм ТУ 3-3.2163-89.


4.4.3 Гадна үзлэгийн явцад загварын гадаад байдал нь Т 416.02.000 СБ ПКБ ЦВ зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно.

Загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн болон гадаад үзэмжийг муутгасан бусад сэв согоггүй байна.

4.4.4 Загварын ажлын гадаргуугийн барзгар 12,5 мкм-ээс ихгүй байна.

4.4.5 Загварын ажлын гадаргууг № 889 р хяналтын загварын тусламжтай шалгана. Хяналтын загварыг шалгагдаж буй загварын ажлын гадаргууд шахаж завсар зайг шупны эсвэл засвар зайн загвартай харьцуулан тодорхойлно.

Хяналтын загвар, ажлын загвар хоорондын завсар зай үйлдвэрээс буюу засвараас гарсан үед 0,5 мм-ээс ихгүй, ашиглалтын болон хадгалалтын үед 0,7 мм-ээс ихгүй байхыг зөвшөөрнө.



Зураг 5. Авто угсрааны холболтын хүрээг шалгах № 827 р шаблон

4.5 Бага шүдний ба амны хөндийн цохилтын гадаргууг шалгах 914/24-1 загварын гадаргуу

4.5.1 Загварын (зураг - 6) шалгалтыг 7-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.

7 – р хүснэгт

Шалгалтын үйл ажиллагаа	зүйлийн дугаар	Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.5.3	тийм	тийм
Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.5.4	тийм	үгүй
Хяналтын хэмжээг шалгах	4.5.5	тийм	тийм

4.5.2 Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслийг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-93;
- хяналтын загвар 889 р (зураг Т 416.00.004);
- шупны цуглуулга № 4 ТУ 2-034-225-87;
- штангенциркуль MNS ISO 13385-1 : 2015;
- төгсгөлт уртын багц хэмжүүр MNS ISO 3650:2005;
- төгсгөлт уртын хэмжүүрийн дагалдах хэрэгслүүд ГОСТ 4119-76 ГОСТ 4119-76;
- шалгалтын хавтан 2-630x400 ГОСТ 10905-86.

4.5.3 Гадна үзлэгийн явцад загварын гадаад байдал нь Т 416.00.007 ПКБ ЦВ зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно.

Загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн болон гадаад үзэмжийг муутгасан бусад сэв согоггүй байна.

4.5.4 Загварын ажлын гадаргуугийн барзгар 12,5 мкм–ээс ихгүй байна.

4.5.5 Загварын гадаргуугийн хяналтын хэмжээ нь 8-р хүснэгтэнд заасны дагуу байна.

8-р хүснэгт

Хяналтын хэмжээний нэр	Зүйлийн дугаар	Хяналтын хэмжээний утга, мм	Ашиглалтын элэгдлийн хүлцэл, мм	Загварын хяналтын хязгаарын хэмжээ, мм	
				Үйлдвэр болон засвараас гарсан үед	Ашиглалт болон хадгалалтын үед
Жижиг шүдний цохилтын гадаргууг шалгах ил гарсан хэсэг	4.5.5.1	478,0±0,2	-0,5	477,8-478,2	477,5-478,2
	--/--	5,9+0,1	-0,3	5,9-6,0	5,6-6,0
Амны хөндийн					

мөргөлтийн гадаргууг шалгах ухаадас	4.5.5.2	515±0,2	-	514,8-515,2	514,8-515,2
Хөндлөвчний нугарсан шугамын хэмжээ	4.5.5.3	159±0,2 160±0,2	-	158,8-159,2 159,8-160,2	158,8-159,2 159,8-160,2
Ухаадасны гүн	4.5.5.4	2±0,1	-	1,9-2,1	1,9-2,1

4.5.5.1 478 мм хэмжээг:

а) үйлдвэрээс буюу засвараас гарсан үед төгсгөлт уртын хэмжүүр, түүний дагалдах хэрэгслийн тусламжтай тодорхойлох ба зөвшөөрөгдөх хязгаарын хэмжээ: 477,8 – 478,2 мм;

б) ашиглалтын болон хадгалалтын үед штангенциркуль ашиглан тодорхойлох ба зөвшөөрөгдөх хязгаарын хэмжээ: 477,5-478,2 мм байна.

5,9 мм хэмжээг дараахь аргаар шалгана:

- Загварын гадаргууг “А” талаар нь шалгалтын тавцанд перпендикуляр байрлуулж, зориулалтын суурьт бэхлэнэ.

- Шалгалтын тавцангаас хяналтын хэмжээний дээд ирмэг хүртэлх зайг төгсгөлт уртын багц хэмжүүр, шупны цуглуулгын тусламжтай хэмжинэ.

Зөвшөөрөгдөх хазайлт:

а) үйлдвэрээс буюу засвараас гарсан үед +0,1 мм-ээс ихгүй;

б) ашиглалтын болон хадгалалтын үед $\begin{matrix} +0.1 \\ -0.3 \end{matrix}$ мм-ээс багагүй байна.

4.5.5.2 515 мм хэмжээг төгсгөлт уртын хэмжүүрийг хоёр радиусан гадаргуу бүхий дагалдах хэрэгслийн хамт бэхлэн тогтооно.

Нэг гадаргуу нь нөгөө гадаргуугаас 10 мм-ээс дээш илүү гарсан байна. Зөвшөөрөгдөх хэмжээний утга 514,8-515,2 мм байна.


4.5.5.3 Нугарсан шугамны 159 мм ба 160 мм хэмжээг төгсгөлт уртын хэмжүүрийг хоёр тэмдэглэгч ирмэг бүхий дагалдах хэрэгслийн хамт бэхлэн тогтооно. Хазайлт нь (±0,2) мм-ээс ихгүй байхыг зөвшөөрнө.

4.5.5.4 Ухаадасны 2 мм гүнийг дараахь аргаар шалгана:

- хөндлөвчийг “Б” гадаргуу талаар нь түүнтэй ижил өндөртэй призм дээр байрлуулж шалгалтын тавцан дээр тавина;

- төгсгөлт уртын хэмжүүр, багц шупны тусламжтай шалгалтын хавтангаас хяналтын хэмжээний дээд ирмэг хүртэл хэмжинэ;

- призмийн өндөр, гарсан хэмжлийн утга хоёрын ялгавраар энэхүү утгыг тодорхойлно. Зөвшөөрөгдөх хэлбэлзэл (±0,1) мм байна.



Зураг 6. Бага шүдний ба амны хөндийн цохилтын гадаргууг шалгах 914/24-1 загварын гадаргуу

4.6 Ордоггүй шуп № 914/21 а

4.6.1 Шупны (зураг - 7) шалгалтыг 8-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.

Шалгалтын үйл ажиллагаа	зүйлийн дугаар	Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.6.3	тийм	тийм
Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.6.4	тийм	үгүй
Хяналтын хэмжээг шалгах	4.6.5	тийм	тийм

4.6.1 Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслийг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:


- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-93;
- микрометр MNS ISO 3611:2005.

4.6.2 Гадна үзлэгийн явцад шупны гадаад байдал нь Т 416.04.000 СБ ПКБ ЦВ зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно.

Шупны ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн болон гадаад үзэмжийг муутгасан бусад сэв согоггүй байна.

4.6.3 Шупны ажлын гадаргуугийн барзгар 12,5 мкм-ээс ихгүй байна.

4.6.4 Шупны $4+0,1$ мм хэмжээг микрометр ашиглан тодорхойлно. Хазайлт нь $(+0,1)$ мм-ээс ихгүй байна.



Зураг 7. Ордоггүй шуп № 914/21 а

4.7 Авто угсрааны амны хөндий ба бага шүдний мөлүүгийн өнцөг шалгах

№ 822 р загвар

4.7.1 Шупны (зураг - 8) шалгалтыг 9-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.

9 – р хүснэгт

Шалгалтын үйл ажиллагаа	зүйлийн дугаар	Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.7.3	тийм	тийм
Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.7.4	тийм	үгүй
Хяналтын хэмжээг шалгах	4.7.5	тийм	тийм

4.7.2 Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслийг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-93;
- радиусын загварын багц №3 ТУ 2-034-228-88;
- шупны цуглуулга №4 ТУ 2-034-225-87;
- өнцгийн призм хэмжүүр ГОСТ 2875-88.

4.7.3 Гадна үзлэгийн явцад загварын гадаад байдал нь Т 416.00.008 ПКБ ЦВ зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно.


Загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн болон гадаад үзэмжийг муутгасан бусад сэв согоггүй байна.

4.7.4 Загварын ажлын гадаргуугийн барзгар 12,5 мкм-ээс ихгүй байна.

4.7.5 Хяналтын R 15 мм хэмжээг радиусын R15 загвар ашиглан шалгана. Радиусны загвар ба ажлын загвар хоорондын зай дурын шүргэлцлийн цэгт үйлдвэрээс болон засвараас гарсны дараа 0,1 мм-ээс ихгүй, ашиглалт болон хадгалалтын үед завсар зайн загвар эсвэл шупны тусламжтай шалгах ба 0,5 мм-ээс ихгүй байхыг зөвшөөрнө.

Загварын 80°45' өнцгийн хэмжээг шалгалтын тэмдэглэгээ тавих аргаар тодорхойлно.

Загварыг цэвэр металл лист дээр эсвэл өөр хатуу материал дээр тавьж загварын өнцгийн ирмэгийн дагуу металаар зурна. Дараа нь загварыг листнээс авч: листэн дээр гарсан зураасыг шугамны тусламжтай хоорондоо огтлолцох хүртэл уртасгаж, өнцгийн призм хэмжүүрийн тусламжтай өнцгийг тодорхойлно. Хэмжээ нь 80°45'±15'-аас ихгүй байна.



Зураг 8. Авто угсрааны амны хөндий ба бага шүдний мөлүүгийн өнцөг шалгах № 822 р загвар

4.8 Авто угсрааны толгойн халаасны өргөн шалгах № 845 р загвар

4.8.1 Загварын (зураг - 9) шалгалтыг 10-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.

Шалгалтын үйл ажиллагаа	зүйлийн дугаар	10-р хүснэгт Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.8.3	тийм	тийм
Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.8.4	тийм	үгүй
Хяналтын хэмжээг шалгах	4.8.5	тийм	тийм

4.8.2 Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслийг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-93;
- микрометр MNS ISO 3611:2005.


4.8.3 Гадна үзлэгийн явцад загварын гадаад байдал нь Т 416.07.000 СБ ПКБ ЦВ зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно.

Загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн болон гадаад үзэмжийг муутгасан бусад сэв согоггүй байна.

4.8.4 Загварын ажлын гадаргуугийн барзгар 12,5 мкм-ээс ихгүй байна.

4.8.5 Загварын хяналтын ($77 \pm 0,1$) мм, ($54,5 \pm 0,1$) мм хэмжээг микрометр ашиглан

тодорхойлно. Хяналтын хэмжээний хэвийн утгын хазайлтын хэмжээ $\pm 0,1$ мм-ээс ихгүй байна.



Зураг 9. Авто угсрааны толгойн халаасны өргөн шалгах № 845 р загвар

4.9 Авто угсрааны толгойн халаасны өргөн шалгах № 848 р загвар

4.9.1 Загварын (зураг - 10) шалгалтыг 11-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.

Шалгалтын үйл ажиллагаа	зүйлийн дугаар	11– р хүснэгт Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.9.3	тийм	тийм
Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.9.4	тийм	үгүй
Хяналтын хэмжээг шалгах	4.9.5	тийм	тийм

4.9.2 Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслүүд ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-93;
- микрометр MNS ISO 3611:2005;
- индикаторт скоба ГОСТ 8.359-79;
- штангенциркуль MNS ISO 13385-1:2015.

4.9.3 Гадна үзлэгийн явцад загварын гадаад байдал нь Т 416.08.000 СБ ПКБ ЦВ зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно.

Загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн болон гадаад үзэмжийг муутгасан бусад сэв согоггүй байна.


4.9.4 Загварын ажлын гадаргуугийн барзгар 12,5 мкм-ээс ихгүй байна.

4.9.5 Загварын хяналтын ($72 \pm 0,2$) мм хэмжээг:

а) үйлдвэрээс буюу засвараас гарсан үед микрометр эсвэл индикаторт скоба ашиглан тодорхойлно. Хазайлтын хэмжээ $\pm 0,2$ мм байхыг зөвшөөрнө.

б) ашиглалтын ба хадгалалтын үед штангенциркуль ашиглан шалгана.

Хазайлтын хэмжээ $\begin{matrix} +0.2 \\ -0.5 \end{matrix}$ мм-ээс ихгүй байна.



Зураг 10. Авто угсрааны толгойн халаасны өргөн шалгах № 848 p загвар

4.10 Өргөгчийн голын нүхний тэнхлэгийн давхцал ба диаметруудийг шалгах

№ 797 р загвар

4.10.1 Загварын (зураг - 11) шалгалтыг 13-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.

13– р хүснэгт

Шалгалтын үйл ажиллагаа	зүйлийн дугаар	Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.10.3	тийм	тийм
Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.10.4	тийм	үгүй
Хяналтын хэмжээг шалгах	4.10.5	тийм	тийм

4.10.2 Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслийг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-93;
- микрометр MNS ISO 3611:2015;
- индикаторт скоба ГОСТ 8.359-79;
- штангенциркуль MNS ISO 13385-1:2015.

4.10.3 Гадна үзлэгийн явцад загварын гадаад байдал нь Т 416.00.009 ПКБ ЦВ зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно.

Загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн болон гадаад үзэмжийг муутгасан бусад сэв согоггүй байна.

4.10.4 Загварын ажлын гадаргуугийн барзгар 12,5 мкм-ээс ихгүй байна.

4.10.5 Шалгалтын үед загварын хяналтын хэмжээ 14-р хүснэгтэд заасны дагуу байна.

14-р хүснэгт

Хяналтын хэмжээний нэр	Зүйлийн дугаар	Хяналтын хэмжээний утга, мм	Ашиглалт -ын элэгдлийн хүлцэл, мм	Загварын хяналтын хязгаарын хэмжээ, мм	
				Үйлдвэр болон засвараас гарсан үед	Ашиглалт болон хадгалалтын үед
Өргөгчийн голонцор хүртэлх жижиг нүхний диаметрийг шалгах загварын ордоггүй хэмжээ	4.10.5.1	Ø35-0,1	-	34,9-35,0	34,9-35,0
Өргөгчийн голонцор хүртэлх жижиг нүхний диаметрийг шалгах загварын ордог хэмжээ	4.10.5.2	Ø31-0,1	-0,5	30,9-31,0	30,5-31,0
Өргөгчийн голонцор	4.10.5.1	Ø53,5-0,1	-	53,4-53,5	53,4-53,5


хүртэлх том нүхний диаметрийг шалгах загварын ордоггүй хэмжээ					
Өргөгчийн голонцор хүртэлх том нүхний диаметрийг шалгах загварын ордог хэмжээ	4.10.5.2	Ø49,0-0,1	-0,5	48,9-49,0	48,5-49,0

4.10.5.1 Хяналтын 35 мм ба 53,5 мм хэмжээг микрометр эсвэл индикаторт скоба ашиглан шалгана. Хэмжилтийг өөр хоорондоо харилцан перпендикуляр 2 хавтгайд гүйцэтгэнэ. Хэвийн хэмжээнээс хазайх хазайлт -0,1 мм-ээс ихгүй байна.

4.10.5.2 Хяналтын 31 мм ба 49 мм хэмжээг

а) үйлдвэрээс буюу засвараас гарсан үед микрометр эсвэл индикаторт скоба ашиглан хэмжихдээ өөр хоорондоо харилцан перпендикуляр 2 хавтгайд гүйцэтгэнэ. Хазайлт нь -0,1 мм-ээс ихгүй байна.

б) ашиглалт, хадгалалтын үед штангенциркуль ашиглана. Хэмжилтийг өөр хоорондоо харилцан перпендикуляр 2 хавтгайд гүйцэтгэнэ. Хазайлт нь (-0,2 мм)-ээс ихгүй байна.



Зураг 11. Өргөгчийн голын нүхний тэнхлэгийн давхцал ба диаметруудийг шалгах № 797 р загвар

4.11 Авто угсрааны холболтын хүрээг өргөгчийн голын нүхний байрлалтай харьцуулан давхцалыг шалгах № 937 р загвар

4.11.1 Загварын (зураг - 12) шалгалтыг 15-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.

15– р хүснэгт

Шалгалтын үйл ажиллагаа	зүйлийн дугаар	Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.11.3	тийм	тийм
Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.11.4	тийм	үгүй
Хяналтын хэмжээг шалгах	4.11.5	тийм	тийм

4.11.2 Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслийг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-93;
- шалгалтын хавтан 2-630x400 ГОСТ 10905-86;
- шалгалтын призм ТУ-2-034-812-88;
- ИРБ микрометр МИ 1928-88;
- Суурь С-17 ГОСТ 10197-70;
- Төгсгөлт уртын хэмжүүр MNS ISO 3650:2005;
- Штангенрейсмас ГОСТ 164-90;
- Шупны цуглуулга ТУ 2-034-225-87;
- Төгсгөлт уртын хэмжүүрийн дагалдах хэрэгслүүд ГОСТ 4119-76;
- Цаг маягийн индикатор ИЧ-2 MNS ISO 463:2016;
- Өнцгийн призм хэмжүүр ГОСТ 3749-77;
- Шалгалтын 2 талт лекаль шугам ЛД-1-125 ГОСТ 8026-75.

4.11.3 Гадна үзлэгийн явцад загварын гадаад байдал нь Т 416.09.000 СБ ПКБ ЦВ зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно.

Загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн болон гадаад үзэмжийг муутгасан бусад сэв согоггүй байна.

4.11.4 Загварын ажлын гадаргуугийн барзгарын 12,5 мкм-ээс ихгүй байна.

4.11.5 Шалгалтын үед загварын хяналтын хэмжээ 16-р хүснэгтэнд заасны дагуу байна.

Хяналтын хэмжээний нэр	Зүйлийн дугаар	Хяналтын хэмжээний утга, мм	Ашиглалтын элэгдлийн хүлцэл, мм	Загварын хяналтын хязгаарын хэмжээ, мм	
				Үйлдвэр болон засвараас гарсан үед	Ашиглалт болон хадгалалтын үед
Жижиг шүдний доод хаалтнаас өргөгчийн голын нүхний тэнхлэг хүртэлх зай	4.11.5.1	86±0,1	-0,5	85,9-86,1	85,5-86,1
Листийн тулгуур гадаргуугаас тулгуур хүртэлх зай	4.11.5.2	188,5±0,1	+0,5	188,4-188,6	188,4-189,0
Загварын нүхний өргөн	4.11.5.3	55±0,1	+0,5	55,0-55,1	55,0-55,5
Тулгуурын өндөр	4.11.5.4	75±0,1	-0,5	74,9-75,1	74,5-75,1
Тулгуурын налуугийн өнцөг	4.11.5.5	67°35'±15'	-	67°20'-67°50'	67°20'-67°50'

4.11.5.1 86 мм хэмжээг дараахь хэлбэрээр шалгана:

- Загварыг “А” гадаргуугаар нь призмд суурилуулж, шалгалтын хавтан дээр параллель байрлуулна.

- “Б” гадаргуугийн параллель байдлыг суурьт бэхэлсэн ИРБ индикатор (индикаторын хөлний шилжилтийн үед заалтууд нь адил байна) ашиглан тодорхойлно.

- Штангенрейсмас ашиглан:

X – шалгалтын хавтангаас “Б” гадаргуу хүртэл;

У – шалгалтын хавтангаас “В” гадаргуу хүртэл;

Төгсгөлт уртын багц хэмжүүр, шупны тусламжтай загварын нүхний диаметрийг тодорхойлно – Z

- Гарах үр дүнг $X - \left(Y - \frac{Z}{2} \right)$ томъёогоор тодорхойлно. Энэ утга нь зөвшөөрөгдөх дараахь хязгаарт байна.

а) үйлдвэрээс болон засвараас гарах үед 85,9-86,1 мм;

б) ашиглалтын болон хадгалалтын үед 85,5-86,1 мм байна.

4.11.5.2 188,5 мм хэмжээг үйлдвэрээс болон засвараас гарах үед харьцуулах хэмжих аргаар шалгана.

Загварыг “Д” суурийн гадаргуугаар шалгалтын тавцанд байрлуулж, түүнтэй перпиндикуляр сууринд бэхлэнэ.

Хяналтын 188,5 мм хэмжээний дээд болон доод ирмэгийн хэмжээтэй төгсгөлт уртын багц хэмжүүр цуглуулж (шалгалтын тавцангаас тулгуурын ирмэг

хүртэл, нөгөө нь шалгалтын тавцангаас загварын хагас дугуй хүртэл) хоёр талт лекаль шугамаар тухайн гадаргуунуудийг харьцуулан шалгана.

Шугам болон багцийн хооронд гэрлэн зураас байх ёсгүй. Хэмжлийн үр дүнгийн утгыг төгсгөлт уртын хэмжүүрийн хоёр багцийн ялгавраар тодорхойлох ба энэ нь 188,4-188,6 мм-ийн зөвшөөрөгдөх хязгаарт байна.

Ашиглалтын үед 188,5 мм хэмжээг штангенрейсмас ашиглан тодорхойлно.

Авагддаг хоёр хөл бүхий штангенрейсмас ашиглан шалгалтын хавтангаас тулгуур хүртэлх зай болон нүхний дээд хагас тойрог хүртэлх зайг хэмжинэ. Энэ хэмжээ нь 188,4-189,0 мм зөвшөөрөгдөх хязгаарт байна.

4.11.5.3 Загварын нүхний 55 мм өргөнийг хоёр хажуу гадаргуу бүхий төгсгөлт уртын багц хэмжүүр, түүний дагалдах хэрэгсэл мөн шупны тусламжтай шалгана. Зөвшөөрөгдөх хазайлт:

- а) үйлдвэрээс болон засвараас гарсан үед +0,1 мм-ээс ихгүй
- б) ашиглалт болон хадгалалтын үед +0,5 мм-ээс ихгүй байна.

4.11.5.4 75 мм хэмжээг суурьт бэхэлсэн цаг маягийн индикатор ашиглан шалгана.

Үүний тулд загварыг сууриар нь шалгалтын хавтан дээр суурилуулна.

Цаг маягийн индикаторыг 75 мм төгсгөлт уртын багц хэмжүүрийн тусламжтай "0" цэгт тохируулна.


Энэ тохиолдолд төгсгөлт уртын багц хэмжүүрийг шалгалтын тавцан дээр байрлуулна. Дараа нь индикаторын хөлийг тулгуурын дээд ирмэгт хүргэж индикаторын заалтыг авна.

Индикаторын заалт ба төгсгөлт уртын хэмжүүрийн уртын (75 мм) алгебр нийлбэр нь зөвшөөрөгдөх утгын хязгаарт байх ёстой:

- а) үйлдвэрээс буюу засвараас гарах үед 74,9-75,1 мм;
- б) ашиглалтын болон хадгалалтын үед 74,5-75,1 мм байна.

4.11.5.5 Тулгуурын өнцгийн налуу $67^{\circ}35'$ -ыг дараахь хэлбэрээр тодорхойлно:

- шалгалтын хавтан дээр загварыг сууриар нь байрлуулна;
- шалгалтын өнцөг хэмжигчийг шалгалтын хавтан ба "E" тулгуурт шахна;
- өнцгийн призм хэмжүүрийн тусламжтай өнцөг хэмжигчид тулгуурын налсан өнцгийг хэмжинэ. Энэ нь $90^{\circ} - (67^{\circ}35' \pm 15') = 22^{\circ}25' \pm 15'$ байна.



Зураг 12. Авто угсрааны холболтын хүрээг өргөгчийн голын нүхний байрлалтай харьцуулан давхцалыг шалгах № 937 р загвар

4.12 Цоож баригчийн өлгүүрийн өндөр шалгах № 849 р загвар

4.12.1 Загварын (зураг-13) шалгалтыг 17-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.

Шалгалтын үйл ажиллагаа	зүйлийн дугаар	Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.12.3	тийм	тийм
Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.12.4	тийм	үгүй
Хяналтын хэмжээг шалгах	4.12.5	тийм	тийм

4.11.2 Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслийг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-93;
- микрометр MNS ISO 3611:2015;
- ашиглалтын үед штангенциркуль MNS ISO 13385-1:2015 хэрэглэнэ.

4.12.3 Гадна үзлэгийн явцад загварын гадаад байдал нь Т 416.10.000 СБ ПКБ ЦВ зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно.

Загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн болон гадаад үзэмжийг муутгасан бусад сэв согоггүй байна.

4.12.4 Загварын ажлын гадаргуугийн барзгар 12,5 мкм-ээс ихгүй байна.


4.12.5 Загварын ордоггүй (54+0,2) мм хэмжээг микрометр ашиглан тодорхойлно.

Хэмжээ нь зөвшөөрөгдөх утгын хязгаар 54,0-54,2 мм байна.

Загварын ордог (51+0,2) мм хэмжээг

а) үйлдвэрээс болон засвараас гарсан үед микрометр ашиглана. Хэмжээ нь зөвшөөрөгдөх утгын хязгаар 51,0-51,2 мм;

б) ашиглалтын болон хадгалалтын үед штангенциркуль ашиглана. Хэмжээ нь зөвшөөрөгдөх утгын хязгаар 50,5-51,2 мм байна.



Зураг 13. Цоож баригчийн өлгүүрийн өндөр шалгах № 849 р загвар

4.13 Цоож баригчийн өлгүүр хурууны диаметр шалгах № 806 р загвар

4.13.1 Загварын (зураг - 14) шалгалтыг 18-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.

Шалгалтын үйл ажиллагаа	зүйлийн дугаар	Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.13.3	тийм	тийм
Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.13.4	тийм	үгүй
Хяналтын хэмжээг шалгах	4.13.5	тийм	тийм

4.13.2 Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслийг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-93;
- индикаторт нутромер ГОСТ 868-2009 эсвэл төгсгөлт уртын багц хэмжүүр MNS ISO 3650:2005.

4.13.3 Гадна үзлэгийн явцад загварын гадаад байдал нь Т 416.11.000 СБ ПКБ ЦВ зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно.

Загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн болон гадаад үзэмжийг муутгасан бусад сэв согоггүй байна. Ялтас нь загварын бариул дээр чөлөөтэй хөдлөхгүй байна.

4.13.4 Загварын ажлын гадаргуугийн барзгар 12,5 мкм-ээс ихгүй байна.

4.13.5 27+0,2 мм ба 31+0,2 мм хэмжээг индикаторт нутромер эсвэл төгсгөлт уртын багц хэмжүүр ашиглан тодорхойлно. Хэмжээ нь дараахь зөвшөөрөгдөх хязгаарт байна.

- 27 мм хэмжээ 27,0 – 27,2 мм-ийн хязгаарт;


- 31 мм хэмжээ

а) үйлдвэрээс буюу засвараас гарах үед

31,0-31,2 мм

б) ашиглалтын болон хадгалалтын үед

31,0-31,5 мм байна.



Зураг 14. Цоож баригчийн өлгүүр хурууны диаметр шалгах № 806 p загвар

4.14 Цоож баригчийн өлгүүр хурууны байрлалыг холболтын хүрээтэй харьцуулж шалгах № 816 p загвар

4.14.1 Загварын (зураг - 15) шалгалтыг 19-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.

Шалгалтын үйл ажиллагаа	зүйлийн дугаар	19-р хүснэгт	
		Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.14.3	тийм	тийм
Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.14.4	тийм	үгүй
Хяналтын хэмжээг шалгах	4.14.5	тийм	тийм

4.14.2 Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслийг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-93;
- шалгалтын хавтан 2-630x400 ГОСТ 10905-86;
- шалгалтын өргөн суурьтай өнцөг хэмжигч;
- цаг маягийн индикатор ИЧ-50 MNS ISO 463:2016;

- штатив;
- төгсгөлт уртын багц хэмжүүр MNS ISO 3650:2005;
- өнцгийн призм хэмжүүр ГОСТ 2875-88;
- шалгалтын лекаль өнцөг хэмжигч, ээлжит шалгалтын үед штангенрейсмас ашиглана.

4.14.3 Гадна үзлэгийн явцад загварын гадаад байдал нь Т 416.12.000 СБ ПКБ ЦВ зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно.

Загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн болон гадаад үзэмжийг муутгасан бусад сэв согоггүй байна.

Загварын хяналтын ухаадасны хязгаарт сум нь гацалтгүй жигд хөдөлж байна.

4.14.4 Загварын ажлын гадаргуугийн барзгарын 12,5 мкм-ээс ихгүй байна.

4.14.5 Шалгалтын үед хяналтын хэмжээ нь 20-р хүснэгтэд заасан утгын дагуу байна.

20-р хүснэгт

Хяналтын хэмжээний нэр	Зүйлийн дугаар	Хяналтын хэмжээний утга, мм	Ашиглалтын элэгдлийн хүлцэл, мм	Загварын хяналтын хязгаарын хэмжээ, мм	
				Үйлдвэр болон засвараас гарсан үед	Ашиглалт болон хадгалалтын үед
Суурийн зүсэлтийн "а" доод ирмэгээр хурц зүү суурилуулсан үед штырийн ажлын гадаргуугаас тулгуур хөндлөвчийн өнцөг хүртэл зай	4.14.5.1	38,5±0,1	+0,5	38,4-38,6	38,4-38,8
Загварын тулгуур гадаргууд хөндлөвчийн тулгуур гадаргуугийн налах өнцөг	4.14.5.2	67°38'±15'	-	67°23' - 67°53'	67°23' - 67°53'

Доорх байрлалд индикаторын заалтыг авна. Цаг маягийн индикатор ашиглан хэмжилтийг хөндлөвч бүрээс штыр хүртэл тусад нь хоёр удаа гүйцэтгэнэ.

Гарсан утга нь зөвшөөрөгдөх утгын хязгаар 38,4-38,6 мм байна. Мөн 38,5 мм хэмжээг төгсгөлт уртын багц хэмжүүрээр харьцуулах хэмжлийн аргаар тодорхойлж болно.

Үүний тулд төгсгөлт уртын хэмжүүрийн 2 багцыг (загварыг суурлуулсан байна), нэгийг нь шалгалтын хавтангаас хөндлөвчийн ирмэг хүртэл, нөгөөг нь шалгалтын хавтангаас штырийн тулгуур гадаргуу хүртэл хэмжээтэйгээр бүрдүүлнэ.

Дараа нь бүрдүүлсэн багцаа загварын тухайн гадаргуутай лекаль шугам болон шупны тусламжтай харьцуулна. Гарах утга нь хоёр багцны ялгавраар тодорхойлогдоно.

Загварын ашиглалтын үед цаг маягийн индикаторын оронд штангенрейсмас ашиглана. Штангенрейсмас ашиглан шалгалтын хавтангаас хөндлөвчийн хурц ирмэг хүртэл (эд анги.1) ба хэмжлийн штырийн тулгуурын ирмэг хүртэл (эд анги.3) хэмжинэ.

Энэ тохиолдолд загварын хурц зүү (эд анги.5) суурийн (эд анги.2) “а” зүсэлтийн ирмэгтэй давхцсан байна.

Дараа нь гаргаж авсан хоёр утгын ялгаврыг олох ба зөвшөөрөгдөх утга 38,4-39,0 мм-ээс хэтрэхгүй байна.

4.14.5.1 36,5 мм хэмжээг үйлдвэрээс болон засвараас гарсан үед дараахь аргаар тодорхойлно:

- Загварыг “А” гадаргуугаар нь шалгалтын тавцан дээр өнцөг хэмжигчийн тусламжтай тэгш хэмтэй байрлуулна.
- сууринд бэхэлсэн цаг маягийн индикаторын тусламжтай хэмжилтийг гүйцэтгэнэ.
- индикаторын хэмжлийн толгойг хөндлөвчийн (эд анги.1) гадаргуугийн ирмэгтэй шүргэлцүүлж, индикаторыг “0” заалтанд тохируулна.


4.42.5 Сумны зөв суурилуулалтыг тодорхойлох нь том хаалтны хэмжлийн (эд анги.5) гадаргуугаас өнцөгийн тулгуур гадаргуу (эд анги.3) хүртэлх зайг тодорхойлж өгдөг ба энэ нь $(1 \pm 0,1)$ мм байх ёстой. Загварын өнцгийн (эд анги.3) “А” гадаргуугаар шалгалтын призмд байрлуулж, шалгалтын тавцан дээр байрлуулна.

Хэмжилтийг дугуй хуваартай (0,02 мм хуваарын хуваагдалтай) эсвэл электрон хуваартай (0,01 мм хуваарын хуваагдалтай) штангенрейсмас ашиглан гүйцэтгэнэ. Дээр заасан хэмжих хэрэгсэл байхгүй тохиолдолд суурь болон штативт бэхэлсэн хэмжлийн толгой ашиглан хэмжилт гүйцэтгэж болно

Загварын сумыг загварын суурин дахь хяналтын ухлаадасны аль нэг ирмэгтэй давхцуулна.

Хэмжлийн толгойн 0 тохиргоог бага зэргийн чирагтай, призмийн өндрөөр (өнцгийн тулгуур гадаргууд тохирох) тохируулна. Дараа нь индикаторын толгойг загварын

хаалтанд (эд анги. 5) шүргэлцүүлж, хэмжилт нь хаалтын дунд хэсгээр хийгдэхээр тохируулна.

Дараа нь загварын сумыг хаалтны нөгөө ирмэгийн хяналтын ухлаадастай шүргэлцүүлж хэмжилт хийнэ.

Хоёр хэмжилтийн арифметик дундажыг тодорхойлно.

Гарсан утга нь дараахь зөвшөөрөгдөх утгын хязгаарт байна.


а) үйлдвэрээс болон засвараас гарах үед

0,9 – 1,1 мм

б) ашиглалтын болон хадгалалтын үед

0,5 -1,1 мм.

Хэмжилтийг загварын сум тус бүрт хийнэ.



Зураг 44. Зорчигчийн вагоны тэнцүүлэгч хавтан шалгах № 780 p-M загвар

4.43 Ачааны вагоны дүүжин зүүлт шалгах № 778 p загвар

4.43.1 Загварын (зураг - 45) шалгалтыг 61-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.

61–р хүснэгт

Шалгалтын үйл ажиллагаа	зүйлийн дугаар	Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.43.3	тийм	тийм
Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.43.4	тийм	үгүй
Хяналтын хэмжээг тодорхойлох	4.43.5	тийм	тийм

4.43.2 Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслийг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-93;
- микрометр MNS ISO 3611:2015;
- индикаторт нутромер ГОСТ 868-2009;
- штангенциркуль MNS ISO 13385-1:2015;
- төгсгөлт уртын хэмжүүр MNS ISO 3650:2005;
- шупны цуглуулга № 4 ТУ 2-034-225-87.

4.43.3 Гадна үзлэгийн явцад загварын гадаад байдал нь Т 416.00.21 ПКБ ЦВ зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно.

Загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн сэв согоггүй байна. Загвар нь мурийж тахийсан байх ёсгүй.

4.43.4 Загварын ажлын гадаргуугийн барзгар 12,5 мкм-ээс ихгүй байна.

4.43.5 Загварын хяналтын хэмжээ нь 62-р хүснэгтэд заасан утгын дагуу байна.

62-р хүснэгт

Хяналтын хэмжээний нэр	Зүйлийн дугаар	Хяналтын хэмжээний утга, мм	Ашиглалтын элэгдлийн хүлцэл, мм	Загварын хяналтын хязгаарын хэмжээ, мм	
				Үйлдвэр болон засвараас гарсан үед	Ашиглалт болон хадгалалтын үед
Шилбэний уртыг шалгах загварын ордог болон ордоггүй хэмжээнүүд	4.43.5.1	168-0,1	-0,5	167,9-168,0	167,5-168,0
	4.43.5.2	173-0,1	-	172,9-173,0	172,9-173,0
Загварын дээд болон доод толгойг шалгах загварын ордог ухлаадас	4.43.5.3	67-0,1	+0,5	66,9-67,0	66,9-67,5
		42,5-0,1	+0,5	42,4-42,5	42,4-43,0
		27-0,1	+0,5	26,9-27,0	26,9-27,5
Зүүлтний толгойн уртыг шалгах загварын ордоггүй ухлаадас	4.43.5.4	62-0,1	-	61,9-62,0	61,9-62,0
Зүүлтний толгойн өргөнийг шалгах	4.43.5.4	23-0,1	-	22,9-23,0	22,9-23,0
		38-0,1	-	37,9-38,0	37,9-38,0

загварын ордоггүй ухлаадас					
-------------------------------	--	--	--	--	--

4.43.5.1 168 мм хэмжээг тодорхойлохдоо:

а) үйлдвэрээс болон засвараас гарах үед микрометр ашиглан шалгана. (– 0,1) мм-ээс ихгүй хазайлтыг зөвшөөрнө.

б) ашиглалтын болон хадгалалтын үед 0,05 мм-ийн хуваарын хуваагдалтай штангенциркуль ашиглан шалгана. (– 0,5) мм-ээс ихгүй хазайлтыг зөвшөөрнө.

4.43.5.2 173 мм хэмжээг микрометр ашиглан шалгана. (– 0,1) мм-ээс ихгүй хазайлтыг зөвшөөрнө.


4.43.5.3 Хэмжээ 67 мм; 42,5 мм; 27 мм-ийг индикаторт нутромер ашиглан шалгана.

а) үйлдвэрээс болон засвараас гарах үед (– 0,1) мм-ээс ихгүй хазайлтыг зөвшөөрнө.

б) ашиглалтын болон хадгалалтын үед $\begin{pmatrix} +0,5 \\ -0,1 \end{pmatrix}$ мм-ээс ихгүй хазайлтыг зөвшөөрнө.

4.43.5.4 62 мм; 23 мм; 38 мм хэмжээг индикаторт нутромер эсвэл төгсгөлт уртын багц хэмжүүр, шуп ашиглан шалгана.

(– 0,1) мм-ээс ихгүй хазайлтыг зөвшөөрнө.



Зураг 45. Ачааны вагоны дүүжин зүүлт шалгах № 778 р загвар
4.44 Зорчигчийн вагоны дүүжин зүүлт шалгах № 781 р загвар

4.44.1 Загварын (зураг - 46) шалгалтыг 63-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.

Шалгалтын үйл ажиллагаа	зүйлийн дугаар	Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.44.3	ТИЙМ	ТИЙМ
Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.44.4	ТИЙМ	үгүй
Хяналтын хэмжээг тодорхойлох	4.44.5	ТИЙМ	ТИЙМ

4.44.2 Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслийг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-93;
- микрометр MNS ISO 3611:2015;
- индикаторт нутромер ГОСТ 868-2009;
- штангенциркуль MNS ISO 13385-1:2015;
- төгсгөлт уртын хэмжүүр MNS ISO 3650:2005;
- шупны цуглуулга № 4 ТУ 2-034-225-87.

4.44.3 Гадна үзлэгийн явцад загварын гадаад байдал нь Т 416.00.022 ПКБ ЦВ зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно.

Загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн сэв согоггүй байна. Загвар нь мурийж тахийсан байх ёсгүй.

4.44.4 Загварын ажлын гадаргуугийн барзгарын 4.43.4-д заасны дагуу шалгана.

4.44.5 Загварын хяналтын хэмжээ нь 63-р хүснэгтэд заасан утгын дагуу байна.

Хяналтын хэмжээний нэр	Зүйлийн дугаар	Хяналтын хэмжээний утга, мм	Ашиглалтын элэгдлийн хүлцэл, мм	Загварын хяналтын хязгаарын хэмжээ, мм	
				Үйлдвэр болон засвараас гарсан үед	Ашиглалт болон хадгалалтын үед
Шилбэний уртыг шалгах загварын ордог болон ордоггүй хэмжээнүүд	4.44.5.1	243-0,1	-0,5	242,9-243,0	242,5-243,0
		250-0,1	-	249,9-250,0	249,9-250,0
Зүүлтний толгойн уртыг шалгах загварын ордоггүй ухлаадас	4.44.5.2	86-0,1	+0,5	85,9-86,0	85,9-86,5
		40-0,1	+0,5	39,9-40,0	39,9-40,5
Зүүлтний толгойн өргөнийг шалгах загварын ордоггүй ухлаадас	4.43.5.4	35-0,1	-	34,9-35,0	34,9-35,0
		82-0,1	-	81,9-82,0	81,9-82,0

4.44.5.1 243 мм ба 250 мм хэмжээг микрометр ашиглан шалгана. 243 мм хэмжээний зөвшөөрөгдөх хазайлт

- а) үйлдвэрээс болон засвараас гарах үед (– 0,1) мм-ээс ихгүй;

б) ашиглалтын болон хадгалалтын үед (– 0,5) мм-ээс ихгүй байна.

250 мм хэмжээний зөвшөөрөгдөх хазайлт нь (– 0,1) мм-ээс ихгүй байна.


4.44.5.2 86 мм ба 40 мм хэмжээг индикаторт нутромер ашиглан шалгах ба зөвшөөрөгдөх хазайлт нь

а) үйлдвэрээс болон засвараас гарах үед (– 0,1) мм-ээс ихгүй.

б) ашиглалтын болон хадгалалтын үед (– 0,5) мм-ээс ихгүй байна.

4.44.5.3 35 мм ба 82 мм хэмжээг төгсгөлт уртын багц хэмжүүр, шуп ашиглан шалгана.

(– 0,1) мм-ээс ихгүй хазайлтыг зөвшөөрнө.



Зураг 46. Зорчигчийн вагоны дүүжин зүүлт шалгах № 781 р загвар

4.45 Авто угсрааны байдал ба түүний механизмын ажиллагааг шалгах № 940 р хосолсон /комбинированный/ загвар

4.45.1 Загварын (зураг - 47) шалгалтыг 65-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.

Шалгалтын үйл ажиллагаа	зүйлийн дугаар	65–р хүснэгт Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.45.3	тийм	тийм
Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.45.4	тийм	үгүй
Загварын хяналтын хэмжээг шалгах	4.45.5	тийм	тийм

4.45.2 Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслийг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-93;
- шалгалтын хавтан 2-630x400 ГОСТ 10905-86;
- шалгалтын өнцөг хэмжигч хавтан II-2;
- өнцөг хэмжигч;
- төмөр шугам;
- штангенциркуль MNS ISO 13385-1:2015;
- төгсгөлт уртын хэмжүүр MNS ISO 3650:2005;
- төгсгөлт уртын хэмжүүрийн дагалдах хэрэгсэл ГОСТ 4119-76;
- шалгалтын призм ТУ 2-034-812-88;
- штатив;
- штангенрейсмас ШР-250 ГОСТ 164-90.

4.45.3 Гадна үзлэгийн явцад загварын гадаад байдал нь Т 416.36.000 ПКБ ЦВ зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно.

Загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн сэв согоггүй байна. Загварын суурь болон хаалт мурийж тахийсан байх ёсгүй.

Загварын сөхөгддөг хаалт нь хязгаарлагчийн хэмжээнд загварын сууриар эрэг дээр чөлөөтэй хөдөлж байх ёстой.

4.45.4 Загварын ажлын гадаргуугийн барзгар 12,5 мкм-ээс ихгүй байна.

4.45.5 Загварын хяналтын хэмжээ нь 66-р хүснэгтэд заасан утгын дагуу байна.

66-р хүснэгт

Хяналтын хэмжээний нэр	Зүйлийн дугаар	Хяналтын хэмжээний утга, мм	Ашиглалтын элэгдлийн хүлцэл, мм	Загварын хяналтын хязгаарын хэмжээ, мм	
				Үйлдвэр болон засвараас гарсан үед	Ашиглалт болон хадгалалтын үед
Цоожны урьдчилан хамгаалагчийн ажиллагааг шалгах хэмжээ	4.45.5.1	95±0,1	-0,5	94,9-95,1	94,5-95,1
Сөхөгддөг хаалтны хяналтын хэмжээ	4.45.5.2	35±0,1	-	34,9-35,1	34,9-35,1
Цоожны цоожлогддог хэсгийн зузааныг шалгах хэмжээ	4.45.5.3	6±0,1 45±0,2 3±0,1	- - -	5,9-6,1 44,8-45,2 2,9-3,1	5,9-6,1 44,8-45,2 2,9-3,1
Амны хөндийн суналтыг шалгах хэмжээ	4.45.5.4	155±0,3	-	154,7-155,3	154,7-155,3
Жижиг шүдний уртыг шалгах хэмжээ	4.45.5.5	99±0,2	-	98,8-99,2	98,8-99,2
Амны цохилтын хананаас том шүдний татах гадаргуу хүртэлх зай шалгах хэмжээ	4.45.5.6	124±0,3	-	123,7-124,3	123,7-124,3

4.45.5.1 95 мм хэмжээг дараахь аргаар шалгана:

Загварыг шалгалтын тавцан дээр суурилуулсан призмд углана.

Лекаль өнцөг хэмжигчийг зураг-47-д заасны дагуу эд анги 2 –ийн суурь хүртэл шахаж байрлуулна. Төгсгөлт уртын хэмжүүр ашиглан өнцгийн шалгалтын хавтангаас загварын гадаргуу хүртэл мөн лекаль өнцөг хэмжигч хүртэлх зайг хэмжинэ. Хоёр хэмжилтийн ялгавраар хэмжээг тодорхойлох ба энэ хэмжээ нь

а) үйлдвэрээс болон засвараас гарах үед 94,9-95,1 мм;

б) ашиглалтын болон хадгалалтын үед 94,5-95,1 мм-ийн зөвшөөрөгдөх хязгаарт байна.

4.45.5.2 35 мм хэмжээг “А” гадаргууд тулгаж байрлуулсан лекаль шугамын тусламжтай төгсгөлт уртын хэмжүүр ашиглан шалгах ба зөвшөөрөгдөх утгын хязгаар 34,9 – 35,1 мм байна.

4.45.5.3 6 мм; 45 мм; 3 мм хэмжээсийг хяналтын тэмдэглээ тавих аргаар шалгана.

Загварыг цэвэр гадаргуутай хатуу материалтай эсвэл металл дээр тавихдаа голонцор нь (эд анги - 4) саад болохгүй байхаар байрлуулна. Ингэхдээ загварын суурийг тэгшлэх зорилгоор нөгөө талд нь жийрэг тавьж өгнө. Тэмдэглэгчээр загварын ухаадасны шалгалтын шугамыг зурж цааш огтлолцох хүртэл нь зурна.

Төгсгөлт уртын хэмжүүрээр зохих хэмжээний хязгаар хүртэл зайг хэмжинэ. Гарган авсан утга нь дараахь зөвшөөрөгдөх утгын хязгаарт байна:

5,9 – 6,1 мм;

44,8 – 45,2 мм;

2,9 – 3,1 мм.


4.45.5.4 155 мм хэмжээг штангенциркуль ашиглан шалгана. Хэмжээ нь дараахь зөвшөөрөгдөх утгын хязгаарт байна: 154,7 – 155,3 мм.

4.45.5.5 99 мм хэмжээг нэг нь тэмдэглээний нөгөө нь хавтгай паралель гадаргуутай хоёр хажуу бүхий төгсгөлт уртын хэмжүүрийн багцны тусламжтай тодорхойлно. Хавтгай паралель гадаргууг загварын том ухлаадаст шахаж, тэмдэглээний гадаргууг ухлаадасны нөгөө талын хамгийн доод цэгт хүргэнэ.

Хэмжээ нь дараахь зөвшөөрөгдөх утгын хязгаарт байна: 98,8 – 99,2 мм.

4.45.5.6 Хэмжээ 124 мм хэмжууг дараахь аргаар шалгана. Загварыг “Б” талаар нь шалгалтын тавцанд байрлуулж тулгуур сууринд бэхлэнэ. Штангенрейсмас ашиглан шалгалтын тавцангаас хяналтын хэмжээний дээд ирмэг хүртэл хэмжинэ. Хэмжээ нь дараахь зөвшөөрөгдөх утгын хязгаарт байна: 123,7 – 124,3 мм.

ТАЙЛБАР: Хэрэв тухайн байгууллагад хэмжлийн микроскоп ашигладаг бол дээрх шалгалтыг энэхүү микроскоп ашиглан гүйцэтгэхийг зөвлөж байна.



Зураг 476 Авто угсрааны байдал ба түүний механизмын ажиллагааг шалгах № 940 р хосолсон /комбинированный/ загвар

4.46 Авто угсрааны байдал, түүний механизмүүдийн үйлчлэлийг шалгах № 873 загвар

4.46.1 Загварын (зураг - 48) шалгалтыг 67-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.

Шалгалтын үйл ажиллагаа	зүйлийн дугаар	Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.46.3	тийм	тийм
Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.46.4	тийм	үгүй
Загварын хяналтын хэмжээг шалгах	4.46.5	тийм	тийм

4.46.2 Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслийг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-93;
- шалгалтын хавтан 2-630x400 ГОСТ 10905-86;
- өнцгийн шалгалтын хавтан II-2 ТУ-2-034-801-75;
- өнцөг хэмжигч;
- штангенциркуль MNS ISO 13385-1:2015;
- төгсгөлт уртын хэмжүүр MNS ISO 3650:2055;
- төгсгөлт уртын хэмжүүрийн дагалдах хэрэгсэл ГОСТ 4119-76;
- цаг маягийн индикатор MNS ISO 463:2016;
- штатив;
- штангенрейсмас ШР-250 ГОСТ 164-90.

4.46.3 Гадна үзлэгийн явцад загварын гадаад байдал нь Т 416.38.000 ПКБ ЦВ зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно. Загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн сэв согоггүй байна. Загварын суурь болон хаалт мурийж тахийсан байх ёсгүй.

4.46.4 Загварын ажлын гадаргуугийн барзгар 6,3 мкм-ээс ихгүй байна.

4.45.5 Загварын хяналтын хэмжээ нь 68-р хүснэгтэд заасан утгын дагуу байна.

Хяналтын хэмжээний нэр	Зүйлийн дугаар	Хяналтын хэмжээний утга, мм	Ашиглалтын элэгдлийн хүлцэл, мм	Загварын хяналтын хязгаарын хэмжээ, мм	
				Үйлдвэр болон засвараас гарсан үед	Ашиглалт болон хадгалалтын үед
Өөрөө салахаас урьдчилан хамгаалагчийн ажиллагааг шалгах хэмжээ	4.46.5.1	98±0,2	-0,5	97,8-98,2	97,5-98,2
Цоожны зузааныг шалгах хэмжээ	4.46.5.2	6±0,1 45,5 ± 0,1 7,5 ± 0,18	- - -	34,9-35,1 45,4-45,6 7,32-7,68	34,9-35,1 45,5-45,6 7,32-7,68
Амны хөндийн суналтыг шалгах хэмжээ	4.46.5.3	155±0,2	-	154,8-155,2	154,8-155,2

Жижиг шүдний уртыг шалгах хэмжээ	4.46.5.4	98±0,2 97±0,2	- -	97,8-98,2 96,8-97,2	97,8-98,2 69,8-97,2
Амны цохилтын хананаас том шүдний татах гадаргуу хүртэлх зай шалгах хэмжээ	4.46.5.5	125±0,2	-	124,8-125,2	124,8-125,2
Авто угсрааны өндрийн ялгавраар шалгах хэмжээ	4.46.5.6	50±0,2 70±0,2 100±0,2	-0,5 -0,5 -0,5	49,8-50,2 69,8-70,2 99,8-100,2	49,5-50,2 69,5-70,2 99,5-100,2

4.46.5.1 98 мм хэмжээг дараахь аргаар шалгана:

Загварыг шалгалтын тавцан дээр суурилуулсан призмд углана. Лекаль өнцөг хэмжигчийг зураг-48-д заасны дагуу эд анги 2 –ийн суурь хүртэл шахаж байрлуулна. Төгсгөлт уртын хэмжүүр ашиглан өнцгийн шалгалтын хавтангаас загварын гадаргуу “Х” хүртэл мөн лекаль өнцөг хэмжигч “У” хүртэлх зайг хэмжинэ. Хоёр хэмжилтийн ялгавраар хэмжээг тодорхойлох ба энэ хэмжээ нь

а) үйлдвэрээс болон засвараас гарах үед 97,8-98,2 мм;

б) ашиглалтын болон хадгалалтын үед 97,5-98,2 мм-ийн зөвшөөрөгдөх хязгаарт байна.

4.46.5.2 6 мм; 45,5 мм; 7,5 мм хэмжээг хяналтын тэмдэглээ* тавих аргаар шалгана.

Загварыг цэвэр гадаргуутай хатуу материал эсвэл металл дээр байрлуулна. Тэмдэглэгчээр загварын ухаадасны шалгалтын шугамыг зурж цааш огтлолцох хүртэл нь зурна.

Төгсгөлт уртын хэмжүүрээр зохих хэмжээний хязгаар хүртэл зайг хэмжинэ. Гарган авсан утга нь дараахь зөвшөөрөгдөх утгын хязгаарт байна:

5,9 – 6,1 мм;

45,4 – 45,6 мм;

7,32 – 7,68 мм.

4.46.5.3 155 мм хэмжээг штангенциркуль ашиглан шалгана. Хэмжээ нь дараах зөвшөөрөгдөх утгын хязгаарт байна: 154,8 – 155,2 мм.

4.46.5.4 97 мм; 99 мм хэмжээг тэмдэглээ тавих аргаар 4.46.5.2-р зүйлд заасны адил тодорхойлно

4.45.5.5 125 мм хэмжээ дараах аргаар шалгана.

- загварыг “А” талаар нь шалгалтын тавцанд байрлуулж тулгуур сууринд бэхлэнэ;

- цаг маягийн индикаторын “0” тохиргоог бага зэргийн чирагтай, төгсгөлт уртын хэмжүүрийн 125 мм-т тохируулна.

- дараа нь индикаторын хөлийг 125 мм-ийн хэмжээний нөгөө талын ирмэгт аваачиж заалтыг авна.

- төгсгөлт уртын хэмжүүрийн багцын урт ба индикаторын заалтын нийлбэр нь дараахь зөвшөөрөгдөх утгын хязгаарт байна: 124,6 – 125,2 мм.

4.46.5.6 50 мм; 70 мм; 100 мм хэмжээг дараахь аргаар тодорхойлно:

- загварыг “Б” талаар нь, лекаль өнцөг хэмжигчийн тусламжтай шалгалтын тавцан дээр перпендикуляр байрлуулна;

- штангенрейсмас ашиглан шалгалтын тавцангаас загварын дээд цэгээс загварын 50; 70; 100 мм-ийн ухлаадаснууд хүртэл хэмжинэ;

- хяналтын хэмжээг шалгалтын тавцангаас загварын тухайн цэг хүртэл хэмжсэн хэмжээ ба зохих ухлаадасны хэмжээ хүртэлх зайны ялгавраар тодорхойлно.

Гарган авсан утга нь дараахь зөвшөөрөгдөх утгын хязгаарт байна:

а) үйлдвэрээс болон засвараас гарах үед

49,8-50,2 мм

69,8-70,2 мм

99,8-100,2 мм


б) ашиглалтын болон хадгалалтын үед

49,5-50,2 мм

59,5-70,2 мм

99,5-100,2 мм.

ТАЙЛБАР: Хэрэв тухайн байгууллагад хэмжлийн микроскоп ашигладаг бол дээрх шалгалтыг энэхүү микроскоп ашиглан гүйцэтгэхийг зөвлөж байна.



Зураг 486 Авто угсрааны байдал, түүний механизмүүдийн үйлчлэлийг шалгах № 873 загвар

4.47 847 р загварын хяналтын № 901 р загвар

4.47.1 Загварын (зураг - 49) шалгалтыг 69-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.

69-р хүснэгт

Шалгалтын үйл ажиллагаа	зүйлийн дугаар	Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.47.3	ТИЙМ	ТИЙМ

Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.47.4	тийм	үгүй
Хяналтын загварын ажлын гадаргууг шалгах	4.47.5	тийм	тийм

4.47.2 Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслийг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-93;
- хэмжлийн микроскоп;
- шупны цуглуулга №4 ТУ 2-034-225-87.

4.47.3 Гадна үзлэгийн явцад шалгалтын загварын гадаад байдал нь Т 416.24.000 СБ ПКБ ЦВ зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно.


Загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн сэв согоггүй байна. Загвар нь мурийж тахийсан байх ёсгүй.

4.47.4 Загварын ажлын гадаргуугийн барзгар 12,5 мкм-ээс ихгүй байна.

4.47.5 Хяналтын загварын ажлын гадаргууг хэмжлийн микроскоп ашиглан шалгана. Ажлын гадаргуугийн хэмжээ нь зурагт заасны дагуу байна.

Хэмжлийн микроскоп байхгүй тохиолдолд хяналтын тэмдэглэгээний аргаар шалгана. Үүний тулд хатуу материал эсвэл металл листэн дээр хяналтын загварын ажлын гадаргууг зурагт заасан хэмжээний дагуу зурна.

Дараа нь зурсан листэн дээрээ хяналтын загварыг тавьж ажлын гадаргуугийн ирмэгүүдийн давхцалыг шупны тусламжтай тодорхойлно. Ирмэгүүдийн зураасны давхцаагүй хэмжээ 0,4 мм-ээс ихгүй байна.



Зураг 496 847 p загварын хяналтын № 901 p загвар
4.48 Авто угсрааны том шүдний татах гадаргууг шалгах № 914 p/25 загвар

4.48.1 Загварын (зураг - 50) шалгалтыг 70-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.

Шалгалтын үйл ажиллагаа	зүйлийн дугаар	70-р хүснэгт Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.48.3	ТИЙМ	ТИЙМ
Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.48.4	ТИЙМ	ҮГҮЙ
Шалгалтын хэмжээг шалгах	4.48.5	ТИЙМ	ТИЙМ

4.48.2 Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслийг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-93;
- микрометр MNS ISO 3611:2015;
- штангенциркуль MNS ISO 13385-1:2015;
- төгсгөлт уртын хэмжүүр MNS ISO 3650:2005;
- төгсгөлт уртын хэмжүүрийн дагалдах хэрэгсэл ГОСТ 4119-76.

4.48.3 Гадна үзлэгийн явцад загварын гадаад байдал нь Т 416.06.000 СБ ПКБ ЦВ зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно. Загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн сэв согоггүй байна. Загвар нь мурийж тахийсан байх ёсгүй.

4.48.4 Загварын ажлын гадаргуугийн барзгар 12,5 мкм-ээс ихгүй байна.

4.48.5 Загварын хяналтын хэмжээ нь 71-р хүснэгтэд заасан утгын дагуу байна.

Хяналтын хэмжээний нэр	Зүйлийн дугаар	Хяналтын хэмжээний утга, мм	Ашиглалтын элэгдлийн хүлцэл, мм	71-р хүснэгт Загварын хяналтын хязгаарын хэмжээ, мм	
				Үйлдвэр болон засвараас гарсан үед	Ашиглалт болон хадгалалтын үед
Тулгуурын том ба жижиг талын урт (эд анги.5)	4.48.5.1	112,4-0,1	-0,5	112,3-112,4	111,9-112,4
	4.48.5.2	113,4-0,2	-0,5	113,2-113,4	112,9-113,4
Ялтасны өргөн (эд анги.1)	4.48.5.3	112,4±0,1	-0,5	112,3-112,5	111,9-112,5

4.48.5.1 112,4 мм хэмжээг харьцуулах хэмжлийн аргаар төгсгөлт уртын хэмжүүр ашиглан тодорхойлно.

Хэмжээ нь дараахь зөвшөөрөгдөх хязгаарт байна:

- а) үйлдвэрээс болон засвараас гарах үед 112,3-112,4 мм
- б) ашиглалтын болон хадгалалтын үед 111,9-112,4 мм.

4.48.5.2 113,4 мм хэмжээг тулгуур бүрд тодорхойлно:

а) үйлдвэрээс болон засвараас гарах үед - хоёр хажуу гадаргуу бүхий төгсгөлт уртын багц хэмжүүр ашиглана.

хэмжээ зөвшөөрөгдөх утгын хязгаар 113,2-113,4 мм байна.

б) ашиглалтын болон хадгалалтын үед - штангенциркуль ашиглана.

хэмжээ зөвшөөрөгдөх утгын хязгаар 112,9-113,4 мм байна.


4.48.5.3 Ялтасны зузаан 112,4 мм хэмжээг тодорхойлоход:

а) үйлдвэрээс болон засвараас гарах үед микрометр ашиглана.

хэмжээ зөвшөөрөгдөх утгын хязгаар 112,3-112,5 мм байна.

б) ашиглалтын болон хадгалалтын үед-штангенциркуль ашиглана.

хэмжээ зөвшөөрөгдөх утгын хязгаар 111,9-112,45 мм байна.



Зураг 50. Авто угсрааны том шүдний татах гадаргууг шалгах № 914 p/25 загвар

4.49 Авто угсрааны жижиг шүдний татах гадаргууг шалгах № 914 р/22-М загвар

4.49.1 Загварын (зураг - 51) шалгалтыг 71-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.

Шалгалтын үйл ажиллагаа	зүйлийн дугаар	71-р хүснэгт Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.49.3	тийм	тийм
Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.49.4	тийм	үгүй
Шалгалтын хэмжээг шалгах	4.49.5	тийм	тийм

4.49.2 Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслийг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-93;
- шупны цуглуулга ТУ 2-034-225-87;
- микрометрэн нутромер ГОСТ 10-88;
- төгсгөлт уртын хэмжүүр MNS ISO 3650:2005;
- төгсгөлт уртын хэмжүүрийн дагалдах хэрэгсэл ГОСТ 4119-76.

4.49.3 Гадна үзлэгийн явцад загварын гадаад байдал нь Т 416.05.000 СБ ПКБ ЦВ зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно. Загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн сэв согоггүй байна.

4.49.4 Загварын ажлын гадаргуугийн барзгар 12,5 мкм-ээс ихгүй байна.

4.49.5 Хяналтын (101+0,2) мм; (98±0,1) мм хэмжээг бэхлэгчид бэхэлсэн хоёр хажуу гадаргуу бүхий төгсгөлт уртын багц хэмжүүрээр тодорхойлно.

Хэмжилтийг зураг дээр үзүүлсэн хэмжлийн ирмгийн гадаргуу хүртэл хийнэ.


Дараахь хазайлтыг зөвшөөрнө:

- а) үйлдвэрээс болон засвараас гарах үед хэмжээ 101 + 0,2 мм; 98±0,1 мм;
- б) ашиглалтын болон хадгалалтын үед 101 + 0,5 мм; 98^{+0,2}_{-0,5} мм.

Хэмжээ (101+0,2) мм –ийг микрометрэн нутромерээр шалгана.

Дараахь хазайлтыг зөвшөөрнө:

- а) үйлдвэрээс болон засвараас гарах үед + 0,2 мм-ээс ихгүй;
- б) ашиглалтын болон хадгалалтын үед + 0,5 мм-ээс ихгүй.



Зураг 51. Авто угсрааны жижиг шүдний татах гадаргууг шалгах № 914 р/22-М загвар

4.50 № 827 р загвар шалгах № 889 шалгалтын загвар

4.50.1 Загварын (зураг - 52) шалгалтыг 72-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.

Шалгалтын үйл ажиллагаа	зүйлийн дугаар	72-р хүснэгт	
		Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.50.3	тийм	тийм
Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.50.4	тийм	үгүй
Хяналтын загварын ажлын гадаргууг шалгах	4.50.5	тийм	тийм

4.50.2 Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслийг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-93;
- хэмжлийн микроскоп;
- шупны цуглуулга №4 ТУ 2-034-225-87.

4.50.3 Гадна үзлэгийн явцад шалгалтын загварын гадаад байдал нь Т 416.00.004 ПКБ ЦВ зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно. Загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн сэв согоггүй байна.


4.50.4 Загварын ажлын гадаргуугийн барзгар 50 мкм-ээс ихгүй байна.

4.50.5 Хяналтын загварын ажлын гадаргууг хэмжлийн микроскоп ашиглан шалгана. Ажлын гадаргуугийн хэмжээ нь зурагт заасан зөвшөөрөгдөх утгын дагуу байна.

Хэмжлийн микроскоп байхгүй тохиолдолд хяналтын тэмдэглэгээний аргаар шалгана. Үүний тулд хатуу материал эсвэл металл листэн дээр хяналтын загварын ажлын гадаргууг зурагт заасан хэмжээний дагуу зурна.

Дараа нь зурсан листэн дээрээ хяналтын загварыг тавьж ажлын гадаргуугын ирмэгүүдийн давхцалыг шупны тусламжтай тодорхойлно.

Ирмэгүүдийн зураасны давхцаагүй хэмжээ 0,4 мм-ээс ихгүй байна.



Зураг 52. № 827 р загвар шалгах № 889 р шалгалтын загвар

4.51 № 828 р загвар шалгах № 896 шалгалтын загвар

4.51.1 Шалгалтын загварын* (зураг - 53) шалгалтыг 73-р хүснэгтэд заасан үйл ажиллагааны дарааллыг баримтлан гүйцэтгэнэ.

Шалгалтын үйл ажиллагаа	зүйлийн дугаар	73-р хүснэгт Шалгалтын үйл ажиллагаа явуулах эсэх	
		анхдагч шалгалтын үед	ээлжит шалгалтын үед
Гадна үзлэг	4.50.3	тийм	тийм
Ажлын гадаргуугийн барзгарын шалгах	4.50.4	тийм	үгүй
Хяналтын загварын ажлын гадаргууг шалгах	4.50.5	тийм	тийм

4.51.2 Шалгалтыг дараахь шалгалтын хэрэгслийг ашиглан гүйцэтгэнэ. Үүнд:

- гадаргуугийн барзгарын загвар ГОСТ 9378-93;
- хэмжлийн микроскоп;
- шупны цуглуулга №4 ТУ 2-034-225-87.


4.51.3 Гадна үзлэгийн явцад шалгалтын загварын гадаад байдал нь Т 416.00.019 ПКБ ЦВ зохион бүтээх баримтын шаардлагад нийцэж байгааг тогтооно. Загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн сэв согоггүй байна.

4.51.4 Загварын ажлын гадаргуугийн барзгар 50 мкм-ээс ихгүй байна.

4.51.5 Хяналтын загварын ажлын гадаргууг хэмжлийн микроскоп ашиглан шалгана. Ажлын гадаргуугийн хэмжээ нь зурагт заасан зөвшөөрөгдөх утгын дагуу байна. Хэмжлийн микроскоп байхгүй тохиолдолд хяналтын тэмдэглэгээний аргаар шалгана. Үүний тулд хатуу материал эсвэл металл листэн дээр хяналтын загварын ажлын гадаргууг зурагт заасан хэмжээний дагуу зурна.

Дараа нь зурсан листэн дээрээ хяналтын загварыг тавьж ажлын гадаргуугийн ирмэгүүдийн давхцалыг шупны тусламжтай тодорхойлно.

Ирмэгүүдийн зураасны давхцаагүй хэмжээ 0,4 мм-ээс ихгүй байна.



Зураг 53. № 828 р загвар шалгах № 896 шалгалтын загвар

5 ШАЛГАЛТЫН ҮР ДҮН

5.1 Анхдагч шалгалтын үр дүнг (үйлдвэрээс гарах үед) дараахь аргаар гаргана.

Үүнд:

- ХШХ-ийг үйлдвэрлэж гаргасан байгууллага техникийн паспортанд анхдагч шалгалт хийсэн тэмдэглэгээ хийнэ;

- ХШХ тус бүр дээр үйлдвэрийн дугаар, тэмдэглэгээ, анхдагч шалгалт хийсэн огноо зэргийг тэмдэглэнэ.

5.2 Анхдагч шалгалтанд хамрагдаагүй ХШХ-ийг үйлдвэрээс гаргахыг хориглоно.

5.3 Анхдагч шалгалтын үр дүнг ВУ-40 дэвтэрт бичнэ.

5.4 Дэвтэрт ХШХ-ийн тэмдэглэгээ, анхдагч шалгалтанд хамрагдсан огноо, дараагийн шалгалтанд хамрагдах хугацаа зэргийг бичиж тэмдэглэнэ.

5.5 Ээлжит шалгалтанд хамрагдаж тэнцсэн ХШХ-д ээлжит шалгалтанд хамрагдсан талаар тэмдэглэгээ хийнэ.

5.6 Ээлжит шалгалтанд тэнцээгүй ХШХ-ийг засварлуулах ба эсвэл ашиглалтаас хасна.

6 ХАВСРАЛТ /лавлагаа/

1. № Т 416.00.004 ПКБ ЦВ 1982г (зураг-54) зургийн дагуу үйлдвэрлэгдсэн №889р хяналтын загварыг шалгах аргачлал

1.1 Гадна үзлэгээр хяналтын загвар нь зохион бүтээцийн зурагт тохирч байгааг тогтооно. Хяналтын загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн сэв согоггүй байна.

1.2 Хяналтын загварын хэмжээ 71,5 мм-ийг дараахь аргаар шалгана:

- Хяналтын загварыг “А” гадаргуугаар нь тэгш өнцөг хэмжигчийн тусламжтай шалгалтын тавцанд перпиндикуляр байрлуулж, суурьт бэхлэнэ;

- дараа нь 71,45 мм ба 71,55 мм-ийн хэмжээтэй төгсгөлт уртын багц хэмжүүр сонгож хоёр талт лекаль шугамын тусламжтай харьцуулах хэмжлийн аргаар хяналтын хэмжээ нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг тодорхойлно. Дээд хэмжээний шугамыг хязгаарлаж байгаа өнцгийн дээд оройн хэмжээ 71,45 мм-ээс их 71,55 мм-ээс бага байх ёстой.

Хяналтын загварын жижиг шүдний хяналтын хэмжээ, төгсгөлт уртын багц хэмжүүрийн хэмжээг харьцуулахдаа суурьт бэхэлсэн ИРБ индикатор ашиглаж болно.

1.3 Хяналтын загварыг 1.2-р зүйлд заасны дагуу шалгалтын тавцан дээр байрлуулж хяналтын хэмжээ 258; 74,7; 52,7; 50,9 мм-ийг тодорхойлно.

1.3.1 Шалгалтын тавцангаас 258 мм-ийн хяналтын хэмжээний дээд ирмэг хүртэлх зайг төгсгөлт уртын багц хэмжүүр ашиглан тодорхойлно. Хэмжилтийг 2-оос доошгүй удаа хяналтын гадаргуу дагуу хийж гүйцэтгэнэ. $\pm 0,05$ мм-ээс ихгүй хазайлтыг зөвшөөрнө.

1.3.2 Хэмжээ 74,7 мм-ийг 1.3.1-р зүйлд заасны дагуу хэмжсэн 258 мм-ийн бодит утга ба шалгалтын тавцангаас 74,7 мм-ийн (том шүдний цохилтын гадаргуугийн хугарлын цэг) доод ирмэг хүртэл хэмжсэн хэмжээ хоорондын ялгавраар тодорхойлно. Хамгийн сүүлийн хэмжээг хоёр талт лекаль шугамын тусламжтай төгсгөлт уртын хэмжүүрээр эсвэл араат шүдэт индикаторын тусламжтай тодорхойлно. Зөвшөөрөгдөх хазайлт нь $\pm 0,05$ мм-ээс ихгүй байна.

1.3.3 Хэмжээ 52,7 мм-ийг 1.3.1; 1.3.2-р зүйлд заасны дагуу хэмжсэн 258 мм ба 74,7 мм-ийн бодит утга ба шалгалтын тавцангаас 52,7 мм-ийн (технологийн ирмэг дэх зевагийн гадаргуугийн шилжилтийн цэг) хэмжээний доод ирмэг хүртэл хэмжсэн гурван хэмжилтийн ялгавраар тодорхойлно. Хамгийн сүүлийн хэмжээг хоёр талт лекаль шугамын тусламжтай төгсгөлт уртын хэмжүүрээр эсвэл араат шүдэт

индикаторын тусламжтай тодорхойлно. Зөвшөөрөгдөх хазайлт нь $\pm 0,05$ мм-ээс ихгүй байна.

1.3.4 Хэмжээ 50,9 мм-ийг 1.3.1-р зүйлд заасны дагуу хэмжсэн 258 мм-ийн бодит утга ба шалгалтын тавцангаас том шүдний 40 мм радиусын хамгийн ил гарсан цэг хүртэлх зай хоорондын ялгавраар тодорхойлно.

Ялгавраар гарах хэмжээг дараахь аргаар тодорхойлно:

- шалгалтын тавцан дээр штангенрейсмасын хэмжлийн гадаргуу нь том шүдний радиусын гадаргууд сайн шахагдсан байхаар байрлуулж винтээр бэхлэнэ;
- Дараа нь шалгалтын тавцангаас штангенрейсмасын хэмжлийн гадаргуу хүртэл төгсгөлт уртын багц хэмжүүрбүрдүүлнэ.
- Суурьт бэхэлсэн ИРБ индикаторыг ашиглан төгсгөлт уртын багц хэмжүүр, штангенрейсмасын хэмжлийн гадаргуу хүртэлх зайг харьцуулна;
- Энэхүү хэмжээний бодит утгыг төгсгөлт уртын багц хэмжүүрийн урт дээр индикаторын заалтыг тооцон гаргана.
- Зөвшөөрөгдөх хазайлт нь $\pm 0,05$ мм-ээс ихгүй байна.

1.4 Хяналтын загварын 90; 62; 112,1 мм-ийн хяналтын хэмжээг дараахь аргаар тодорхойлно.

Хяналтын загварыг “В” гадаргуугаар нь тэгш өнцөг хэмжигчийн тусламжтай шалгалтын тавцанд перпиндикуляр байрлуулж, суурьт бэхлэнэ.

1.4.1 Хэмжээ 90 мм-ийг шалгалтын тавцангаас том шүдний цохилтын гадаргуугийн 90 мм-ийн хязгаарын шугам хүртэлх хяналтын гадаргуу хооронд төгсгөлт уртын багц хэмжүүр бүрдүүлэн шалгана.

Лекаль шугам эсвэл суурьт бэхэлсэн араат шүдэт индикаторын тусламжтай төгсгөлт уртын багц хэмжүүрийн гадаргуу ба хяналтын загварын хяналтын гадаргуу хоорондын хэмжээг харьцуулна.

Хяналтын хэмжээ 90 мм-ийн бодит утгыг төгсгөлт уртын багц хэмжүүрийн урт дээр индикаторын заалтыг нэмж тооцон гаргана. Хэмжээ 90 мм-ийн бодит утга ($90 \pm 0,05$) мм-ээс хэтрэх ёсгүй.

1.4.2 Хяналтын хэмжээ 62 мм-ийг шалгалтын тавцангаас 62 мм-ийн (жигжиг шүдний цохилтын гадаргуу) дээд хязгаарын шугам хүртэл ба 1.4.1-р зүйлд заасны дагуу хэмжсэн 90 мм-ийн бодит утгыг хэмжсэн хоёр хэмжилтийн ялгавраар тодорхойлно. Эхний хэмжээг хоёр талт лекаль шугамын тусламжтай төгсгөлт уртын хэмжүүрээр эсвэл араат шүдэт индикаторын тусламжтай тодорхойлно. Зөвшөөрөгдөх хазайлт нь $\pm 0,05$ мм-ээс ихгүй байна.

1.4.3 Хяналтын хэмжээ 112,1 мм-ийг шалгалтын тавцангаас 112,1 мм-ийн хэмжээсийн дээд ирмэг дэхь хяналтын гадаргуу хүртэл хэмжээ ба авто угсрааны том шүдний татах гадаргуу ба 1.4.1-р зүйлд заасны дагуу 90 мм-ийн бодит утгыг хэмжсэн хоёр хэмжилтийн ялгавраар тодорхойлно. Эхний хэмжээг төгсгөлт уртын багц хэмжүүр, шупны тусламжтай тодорхойлно. Зөвшөөрөгдөх хазайлт нь $\pm 0,05$ мм-ээс ихгүй байна.


1.5 Хяналтын хэмжээ 108,4 мм-ийг дараахь аргаар тодорхойлно. Үүнд:

- хоёр тал нь тэгш хавтгай болон хурц ирмэгт гадаргуу бүхий 108,45 мм-ийн төгсгөлт уртын багцыг дагалдах хэрэгслийн тусламжтай бүрдүүлнэ;

- төгсгөлт уртын багц хэмжүүрийг хяналтын загварын жижиг шүдэн дээр тэгш хавтгай талыг авто угсрааны жижиг шүдний цохилтын гадаргууг шалгах гадаргууд нягт шахаж, харин хурц ирмэгт гадаргуу нь радиус 3 нь шууд босоод шилжих цэгт байхаар байрлуулна. Хэмжилтийг өндрийн дагуу хийнэ. 0,1 мм-ийн зузаантай шуп хяналтын загвар ба хурц ирмэгт гадаргуу хооронд орох ёсгүй.

1.6 Хэмжээ 52 мм-ийг хяналтын тэмдэглээ хийх аргаар тодорхойлно. Хяналтын загварыг металл болон хатуу цэвэр лист дээр байрлуулна. Металл тэмдэглэгчээр хяналтын загварын “А”; “С”; “Д” гадаргууг лист дээр тэмдэглэнэ. Дараа нь хяналтын загварыг листнээс авч шугам ба тэмдэглэгчийн тусламжтай “С”; “Д” зураасыг хооронд нь огтлолцтол нь үргэлжлүүлнэ.

Огтлолцлын энэ цэгээс “А” гадаргууд перпиндикуляр шугамыг зурна. Энэ перпиндикулярын уртыг штангенциркуль ашиглан хэмжих ба $(52 \pm 0,2)$ мм-ээс хэтрэх ёсгүй.



Зураг 54. №827р загварыг шалгах №889р хяналтын загвар

2. № Т 416.00.0,19 ПКБ ЦВ (зураг -55) зургийн дагуу үйлдвэрлэгдсэн № 896 р хяналтын загварын шалгалтын аргачлал

2.1 Гадна үзлэгээр хяналтын загвар нь зохион бүтээцийн зурагт тохирч байгааг тогтооно. Хяналтын загварын ажлын гадаргуу нь ан цав гараагүй, цохигдож, зэвэрсэн сэв согоггүй байна.

2.2 Хяналтын загварын хэмжээ 123,7 мм-ийг дараахь аргаар шалгана:

- Хяналтын загварыг “А” гадаргуугаар нь тэгш өнцөг хэмжигчийн тусламжтай шалгалтын тавцанд перпиндикуляр байрлуулж, суурьт бэхлэнэ;

- дараа нь 123,65 мм ба 123,75 мм-ийн хэмжээтэй төгсгөлт уртын багц хэмжүүр сонгож хоёр талт лекаль шугамын тусламжтай харьцуулах хэмжлийн аргаар хяналтын хэмжээ нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг тодорхойлно. Дээд хэмжээний шугамыг хязгаарлаж байгаа өнцөг нь 123,65 мм-ээс их 123,75 мм-ээс бага байна. Хяналтын загварын жижиг шүдний хяналтын хэмжээ, төгсгөлт уртын багц хэмжүүрийн хэмжээг харьцуулахдаа суурьт бэхэлсэн ИРБ индикатор ашиглаж болно.

2.3 Хяналтын загварыг 2.2-р зүйлд заасны дагуу шалгалтын тавцан дээр байрлуулж хяналтын хэмжээ 258; 74; 46; 50,9 мм-ийг тодорхойлно.

2.3.1 Шалгалтын тавцангаас 258 мм-ийн хяналтын хэмжээний дээд ирмэг хүртэлх зайг төгсгөлт уртын багц хэмжүүр, шуп ашиглан тодорхойлно. Хэмжилтийг 2-оос доошгүй удаа хийж гүйцэтгэнэ. $\pm 0,05$ мм-ээс ихгүй хазайлтыг зөвшөөрнө.

2.3.2 Хэмжээ 74 мм-ийг 2.3.1-р зүйлд заасны дагуу хэмжсэн 258 мм-ийн бодит утга ба шалгалтын тавцангаас 74 мм-ийн (том шүдний цохилтын гадаргуугийн хугарлын цэг) доод ирмэг хүртэл хэмжсэн хэмжээ хоорондын ялгавраар тодорхойлно. Хамгийн сүүлийн хэмжээг хоёр талт лекаль шугамын тусламжтай төгсгөлт уртын хэмжүүрээр эсвэл араат шүдэт индикаторын тусламжтай тодорхойлно. Зөвшөөрөгдөх хазайлт нь $\pm 0,05$ мм-ээс ихгүй байна.

2.3.3 Хэмжээ 46 мм-ийг 2.3.1; 2.3.2-р зүйлд заасны дагуу хэмжсэн 258 мм ба 74 мм-ийн бодит утга ба шалгалтын тавцангаас 46 мм-ийн (технологийн ирмэг дэхь зевагийн гадаргуугийн шилжилтийн цэг) хэмжээний доод ирмэг хүртэл хэмжсэн гурван хэмжилтийн ялгавраар тодорхойлно. Хамгийн сүүлийн хэмжээг хоёр талт лекаль шугамын тусламжтай төгсгөлт уртын хэмжүүрээр эсвэл араат шүдэт индикаторын тусламжтай тодорхойлно. Зөвшөөрөгдөх хазайлт нь $\pm 0,05$ мм-ээс ихгүй байна.

2.3.4 Хэмжээ 50,9 мм-ийг 2.3.1-р зүйлд заасны дагуу хэмжсэн 258 мм-ийн бодит утга ба шалгалтын тавцангаас том шүдний 40 мм радиусын хамгийн ил гарсан цэг хүртэлх зай хоорондын ялгавраар тодорхойлно.

Ялгавраар гарах хэмжээг дараахь аргаар тодорхойлно:

- шалгалтын тавцан дээр штангенрейсмасын хэмжлийн гадаргуу нь том шүдний радиусын гадаргууд сайн шахагдсан байхаар байрлуулж винтээр бэхлэнэ;
- дараа нь шалгалтын тавцангаас штангенрейсмасын хэмжлийн гадаргуу хүртэл төгсгөлт уртын багц хэмжүүр бүрдүүлнэ.
- Суурьт бэхэлсэн ИРБ индикаторыг ашиглан төгсгөлт уртын багц хэмжүүр, штангенрейсмасын хэмжлийн гадаргуу хүртэлх зайг харьцуулна;
- Энэхүү хэмжээний бодит утгыг төгсгөлт уртын багц хэмжүүрийн урт дээр индикаторын заалтыг нэмж тооцон гаргана.
- Зөвшөөрөгдөх хазайлт нь $\pm 0,05$ мм-ээс ихгүй байна.

2.4 Хяналтын загварын 112,1 мм-ийн хяналтын хэмжээг дараахь аргаар тодорхойлно:

- хяналтын загварыг “В” гадаргуугаар нь тэгш өнцөг хэмжигчийн тусламжтай шалгалтын тавцанд перпиндикуляр байрлуулж, суурьт бэхлэнэ.

- шалгалтын тавцангаас том шүдний цохилтын гадаргуугийн 90 мм-ийн хязгаарын шугам хүртэлх хяналтын гадаргуу хооронд төгсгөлт уртын багц хэмжүүр бүрдүүлнэ;

- лекаль шугам эсвэл суурьт бэхэлсэн араат шүдэт индикаторын тусламжтай төгсгөлт уртын багц хэмжүүрийн гадаргуу ба хяналтын загварын хяналтын гадаргуу хоорондын хэмжээг харьцуулна;

- дараа нь шалгалтын тавцангаас хяналтын загварын шалгалтын гадаргуугийн 112,1 мм хэмжээсийн дээд ирмэг хүртэлх зай ба авто угсрааны том шүдний татах гадаргуу хүртэлх зайг хэмжинэ. Хэмжсэн хоёр зайны бодит утгын ялгавраар хэмжлийн утгыг гаргаж авна. Зөвшөөрөгдөх хазайлт нь $\pm 0,05$ мм-ээс ихгүй байна.

2.5 Хяналтын хэмжээ 108 мм-ийг дараахь аргаар тодорхойлно. Үүнд:

- хоёр тал нь тэгш хавтгай болон хурц ирмэгт гадаргуу бүхий 108,45 мм-ийн төгсгөлт уртын багц хэмжүүрийг дагалдах хэрэгслийн тусламжтай бүрдүүлнэ;


- төгсгөлт уртын багц хэмжүүрийг хяналтын загварын жижиг шүдэн дээр тэгш хавтгай талыг авто угсрааны жижиг шүдний цохилтын гадаргууг шалгах гадаргууд нягт шахаж, харин хурц ирмэгт гадаргуу нь радиус 3 нь шууд босоод шилжих цэгт

байхаар байрлуулна. Хэмжилтийг өндрийн дагуу хийнэ. 0,1 мм-ийн зузаантай шуп хяналтын загвар ба хурц ирмэгт гадаргуу хооронд орох ёсгүй.

2.6 Хэмжээ 53 мм-ийг хоёр хурц ирмэг бүхий гадаргуутай төгсгөлт уртын багц хэмжүүрээр тодорхойлно. Зөвшөөрөгдөх хазайлт нь $\pm 0,05$ мм-ээс ихгүй байна.

2.7 Хэмжээ 52 мм-ийг хяналтын тэмдэглээ хийх аргаар тодорхойлно. Хяналтын загварыг металл болон хатуу цэвэр лист дээр байрлуулна. Металл тэмдэглэгчээр хяналтын загварын “А”; “С”; “Д” гадаргууг лист дээр тэмдэглэнэ. Дараа нь хяналтын загварыг листнээс авч шугам ба тэмдэглэгчийн тусламжтай “С”; “Д” зураасыг хооронд нь огтлолцтол нь үргэлжлүүлнэ.

Огтлолцлын энэ цэгээс “А” гадаргууд перпендикуляр шугамыг зурна. Энэ перпендикулярын уртыг штангенциркуль ашиглан хэмжих ба $(52\pm 0,2)$ мм-ээс хэтрэх ёсгүй.



Зураг 55. №828 р загварыг шалгах №896 р хяналтын загвар

Ном зүй

- ГОСТ 9378-93 (ISO 2632-1-85, ISO 2632-2-85), Гадаргуугийн барзгарын загвар, Техникийн ерөнхий нөхцөл
- ГОСТ 10905-85, Шалгалтын болон тэмдэглээний хавтан, Техникийн нөхцөл
- МИ 1799-87, Шалгалтын 90° -ын өнцөг хэмжигчийн заавар, Шалгах аргачлал
- ГОСТ 8.003-2010, Хэмжлийн микроскоп, Баталгаажуулалтын арга, хэрэгсэл